

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2016 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

№	Эрх зүйн үндэслэл	Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилт	Хэрэгж илт, хувь
<i>Нэг. Байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн нийт ажил үйлчилгээ</i>						
Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд						
1.	Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 274.4	Төр засгийг иргэдэд нээлттэй, тунгалаг болгох цогц арга хэмжээ авах	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлд салбарын чиглэлээр тусгах саналыг боловсруулах	Хуулийн хугацаанд саналыг өгсөн байна.	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын зорилтын саналыг нэгтгэн ЗГХЭГ-г хүргүүлж, Улсын Их Хурлын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 45 дугаар тогтоолоор батлав. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн батлав.	100
2.	Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.2, 7.1.3, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйл		Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлттэй холбогдуулж сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагыг байгуулах, өөрчлөн зохион байгуулах асуудлыг боловсруулан шийдвэрлүүлэх	Хуулийн хугацаанд саналыг өгсөн байна.	Сайдын эрхлэх хүрээний төсвийн байгууллага Малын удмын сангийн үндэсний төвийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг боловсруулж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны А-66 тушаалаар батлуулав. Мөн аймгийн ХХААГ-уудын зохион байгуулалтын бүтцийн чиг үүргийг шинээр тодорхойлж, орон тооны дээд хязгаарыг ЗГХЭГ-г хүргүүлж, хэлэлцүүлэн аймгийн ХХААГ-уудад Сайдын албан тоотоор хүргүүлсэн.	100
3.	Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.12 заалт	Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарыг бие даасан, цөөн орноос хамааралтай байдлыг арилгахад анхаарч өрсөл-дөх чадварыг нь бэхжүүлэх;	Үржлийн малын үзэсгэлэн, үнэ хаялцах худалдаа зохион байгуулах журам болон Үржлийн мал бойжуулах, борлуулах журмыг нэгтгэн өөрчилж боловсруулах;	Журмыг ХХАА-н сайдын тушаалаар батлуулсан байна.	Журмын төслийг эцэслэн боловсруулж, хэлэлцүүлж, батлуулахад бэлэн болгосон. Одоогийн хуулиар сайдад тус журмыг батлах тусгайлан эрх олгогдоогүй тул журмыг захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрээр ХЗДХ-ийн яаманд бүртгүүлэх боломжгүй гэсэн үндэслэлээр хүлээгдэж байна. Малын генетик нөөцийн тухай хуулийн төсөлд тухайлсан нэрээр хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайдад эрх олгох заалтыг тусгасан. Уг хуулийн төслийг Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.	70

4.	УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол мал үндэсний хөтөлбөрийн 3.1.1 заалт, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.3.78.4 заалт	Мал аж ахуйн салбар дахь хууль тогтоомжийг боловсронгуй болгох, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;	“Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 дахь үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулах;	УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоол, Хөгж-лийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, салбарын дунд хугацааны төсвийн төсөөлөлд үндэслэн боловсруулж батлуулсан байна.	“Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2 дахь үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, УИХ-ын 2010 оны 23 дүгээр тогтоол, хөтөлбөрийн эхний үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээ, салбарын дунд хугацааны төсвийн төсөөлөлд тус тус үндэслэн боловсруулж, төслийг 21 аймагт хэлэлцүүлэн орон нутгийн иргэд, холбогдох харъяа байгууллага, бүтцийн нэгжээс санал авч тусгасан. Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А-61 дүгээр тушаалаар төлөвлөгөөг батлуулсан.	100
5.			“Малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулж батлуулах;	Стратеги төлөвлөгөөг сайдын тушаалаар батлуулсан байна.	Одоогийн мөрдөгдөж буй “Малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлгийг мэргэжлийн холбоо, судлаачид, малчдын төлөөллийн дунд зохион байгуулсан. Төлөвлөгөөний төслийг Зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгүүлэхээр ажлын даалгаврыг боловсруулан сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, мэргэжлийн ТББ-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн боловч санхүүжилтийг шийдвэрлэх асуудал удааширнаас хэрэгжилт удаашираад байна. Гүйцэтгэл хангалтгүй байсан тул уг ажлыг хүлээж авах боломжгүй байна.	70
6.	Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.31.1 заалт	Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарыг бие даасан, цөөн орноос хамааралтай байдлыг арилгахад анхаарч өрсөлдөх чадварыг нь бэхжүүлэх	Мал, тэжээвэр амьтдын үржил, селекцийн ажлын дүнг хянан магадлах, баталгаажуулах, бүртгэх, хяналт тавих журмын төслийг шинэчлэн боловсруулж батлуулах;	Журмын төслийг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын тушаалаар батлуулсан байна.	Журмын төслийг эцэслэн боловсруулж, хэлэлцүүлж, батлуулахад бэлэн болгосон. Одоогийн хуулиар сайдад тус журмыг батлах тусгайлан эрх олгогдоогүй байгаа тул журмыг захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрээр ХЗДХ-ийн яаманд бүртгүүлэх боломжгүй байна. Малын генетик нөөцийн тухай хуулийн төсөлд тухайлсан нэрээр хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайдад эрх олгох заалтыг тусгасан. Уг хуулийн төслийг Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.	70
7.			Гойд ашиг шимт мал шалгаруулах журмын төслийг шинэчлэн боловсруулж батлуулах;	Журмын төслийг сайдын тушаалаар батлуулсан байна.	Журмын төслийг эцэслэн боловсруулж, хэлэлцүүлж, батлуулахад бэлэн болгосон. Одоогийн хуулиар сайдад тус журмыг батлах	70

					тусгайлан эрх олгогдоогүй байгаа тул журмыг захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрээр ХЗДХ-ийн яаманд бүртгүүлэх боломжгүй байна. Малын генетик нөөцийн тухай хуулийн төсөлд тухайлсан нэрээр хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайдад эрх олгох заалтыг тусгасан. Уг хуулийн төслийг Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.	
8.			Малын генийн санд генетик материалыг байршуулах, бүртгэх, зарцуулах, хяналт тавих тухай журмын төслийг батлуулах;	Журмын төслийг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын тушаалаар батлуулсан байна.	Журмын төслийг эцэслэн боловсруулж, хэлэлцүүлж, батлуулахад бэлэн болгосон. Одоогийн хуулиар сайдад тус журмыг батлах тусгайлан эрх олгогдоогүй байгаа тул журмыг захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрээр ХЗДХ-ийн яаманд бүртгүүлэх боломжгүй байна. Малын генетик нөөцийн тухай хуулийн төсөлд тухайлсан нэрээр хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайдад эрх олгох заалтыг тусгасан. Уг хуулийн төслийг Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.	70
9.	“Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөр	Түүхий эдийн хангамжийг тогтворжуулах, эргэлтийн нөөц бүрдүүлэх, нэмэгдүүлэх, боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах;	Тариалангийн бүтээгдэхүүний хадгалалтын үеийн хэвийн хорогдлын норм тооцох журам боловсруулах;	Журмын төслийг боловсруулан сайдын тушаалаар батлуулсан байна.	“Хүнсний буудайг хүлээн авах, хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлал”-ыг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А-80 дугаар тушаалаар батлуулсан. Нийтээр дагаж мөрдөх аргачлал тул ХЗДХЯ-нд бүртгүүлэхээр хүргүүлсэн.	100
10.	“Хүнс, хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого” 6.1.7 дахь заалт	Хүнс, хөдөө аж ахуйн салбарт санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх, төлөвшүүлэх;	Газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх;	Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, батлуулсан байна.	“Санхүүгийн түрээсийн үйлчилгээ нэвтрүүлэх, багалгаа гаргах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан. Хөгжлийн банк санхүүгийн түрээсийн үйлчилгээг нэвтрүүлэх нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхээр шаардлагатай судалгаа, тооцоо хийж байгаа тул уг арга хэмжээг түр түдгэлзүүлээд байна.	70
11.	Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр	Зориулалтын бус хуванцар савнаас бохирлогдсон	“Хүнсний сав баглааны аюулгүй байдал” үндэсний хөтөлбөр боловсруулах;	Хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн	Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор “Сав, баглаа, боодол” үндэсний хөтөлбөрийг баталсан. Уг хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан	100

	тогтоолоор баталсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 4.1.10 дахь заалт	хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах		нарийн бичгийн даргаар ажиллах, төсөл боловсруулсан байх	зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж яамдын саналыг тусган ЗГХЭГ-г хүргүүлж, Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор батлуулав.	
12.	Монгол Улсын Их Хурлын 2012 оны 67 дугаар тогтоол	Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиудад заасан дүрэм, журам, аргачлал, зөвлөмжийг батлах	Хүнсний чиглэлийн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх тухай журмын төсөл боловсруулах;	Хэлцэгдсэн байх, журмын төсөл боловсруулсан байх;	Ажлын хэсэг Хүнсний үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх тухай журмын төсөл боловсруулж, бэлэн болгосон.	100
13.	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 4.1.2 дахь заалт	Эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр хүн амыг жигд хүртээмжтэй хангах, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах, импорт орлох хүнсний үйлдвэрлэлийг дэмжих	Хүнсний аюулгүй байдал үндэсний хөтөлбөрийн төслийг шинэчлэн боловсруулах	Хөтөлбөрийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан байх	“Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 2016 онд дуусгавар болж буйтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” хөтөлбөр хэрэгжүүлэхээр тусгасан. Уг хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны А/159 дугаар тушаалаар байгуулж, хөтөлбөрийн төсөл боловсруулах нөхцөл байдлын дүн шинжилгээ хийхээр ажиллаж байна.	50
14.	2012-2016 онд хэрэгжүүлэх ЗГ газрын мөрийн хөтөлбөрийн 1.31.2	Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарыг бие даасан цөөн орноос хамааралтай байдлыг арилгахад анхаарч өрсөлдөх чадварыг нь бэхжүүлэх	ХХААЯ-ны ШУТСЗ-ийн ажлыг зохион байгуулах	ШУТСЗ-ийн тайлан, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлсэн байна.	Тус яамны шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн 2015 оны ажлын тайланг нэгтгэн гаргаж, 2016 оны ажлын төлөвлөгөөг боловсруулж төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг бүрэн зохион байгуулсан.	100

15.		Салбарын инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулна.	Салбарын инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах	Хөтөлбөр боловсруулан Сайдын тушаалаар батлуулсан байна.	Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх инновацийн хөтөлбөрийг боловсруулан Сайдын 2016 оны А-43 дугаар тушаалаар батлуулан хэвлэн нийтэлсэн.	100
16.	Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг	Салбарын хууль, тогтоомжийг боловсронгуй болгох	Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний үед мөрдөх стандарт ажлын дэг боловсруулах	Стандарт ажлын дэгийг батлуулан мөрдөж эхэлсэн байх.	Хонь, ямааны цэцэг өвчинтэй тэмцэх стратеги, төлөвлөгөө, зааврыг боловсруулан 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанаас гарсан тэмдэглэлийн дагуу Сайдын тушаалаар батлуулав.	100
17.	хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 78.7 дахь заалт					
18.	Монгол мал үндэсний хөтөлбөрийн 3.3.1.3, Засгийн газрын 2012-2016 оны үйл	Салбарын хууль, тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоон боловсронгуй болгох	Мал эмнэлгийн ариун цэвэр, хорио цээрийн хяналтын цэгийн үйл ажиллагааны журмын төсөл боловсруулах	Журмын төслийг Засгийн газраар батлуулсан байх	Мал эмнэлгийн хяналтын цэгт хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмын төслийг боловсруулан Засгийн газрын 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанаас гарсан 25 дугаар тэмдэглэлийн дагуу Сайдын тушаалаар батлуулав.	100
19.	ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 168.3. дахь заалт					
20.			Малын эмчид итгэмжлэл олгох тогтолцоог шинэчлэх, холбогдох журам,	Сайдын тушаалаар батлуулсан байх	“Мал амьтны эрүүл мэндийн тухай” хууль батлагдсаны дараа журмыг боловсруулна. Мал,	0

			Малын эмчийн ёс зүйн дүрмийг шинээр боловсруулах		амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төслийг Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, гишүүдийн саналыг тусган 12 дугаар сарын 26-ны өдөр дахин хэлэлцүүлэхээр тогтсон.	
21.	МУ-ын иргэний хууль, бусад хууль тогтоомж, УИХ болон Засгийн газрын тогтоол, салбарын хууль тогтоомжийн холбогдох шаардлага	Салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны батлагдсан төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлаар хийгдэх арга хэмжээнүүдийн гэрээ, гэрээ дүгнэсэн тэмдэглэлийг хянах, нэгдсэн дугаар олгох, бүртгэх	Төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлаар хийгдэх арга хэмжээ-нүүдийн гэрээ хууль журамд нийцсэн байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар болон урсгал зардлын санхүүжилтээр хийгдэх ажил гүйцэтгэх, бараа нийлүүлэх, зөвлөх үйлчилгээ болон бондын санхүүжилтээр хийгдэж байгаа бодлогын гэрээнүүдийн эрх зүйн үндэслэл, холбогдох материалын иж бүрдэл нь хууль тогтоомж болон бусад шийдвэрт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаж байна. Нийт 182 гэрээний эрх зүйн үндэслэлийг хянаад байна. Гэрээний нэгдсэн сан үүсгэж, газар хэлтэс бүрээр дугаарлан архивлаж, гэрээг буцаасан шалтгааныг нэг бүрчлэн тэмдэглэж, хариуцсан мэргэжилтнээр баталгаажуулж, архивлан хадгалж байгаа бөгөөд шаардалагатай тохиолдолд гэрээг эх хувиар болон хуулбар хувиар гэрээний нэгдсэн сан үүсгэн хадгалж байна.	100
22.	Төсвийн тухай хууль	Салбарын хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд эдийн засгийн дүн шинжилгээ хийх, үр дүнг тооцох;	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогын зорилтыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдийн төсөв боловсруулах, зохих тодотгол өөрчлөлт оруулах, тэдгээрийг хэрэгжүүлэхэд эдийн засгийн тооцоо үндэслэл гаргах;	ХХАА-н салбарын бодлогын зорилтыг хэрэгжүүлэх хөтөлбөр, төслүүдийн төсвийг эдийн засгийн тооцоотой боловсруулсан байна.	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын “Төлөвлөгөө батлах тухай” 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А-160 дугаар тушаал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2016 оны А-68 дугаар тушаалыг тус тус батлуулж санхүүжүүлэн ажиллав. Хүнс, хөдөө аж ахуйн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны батлагдсан төсвийг яамны цахим хуудаст байршуулан ажилласан. Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийг 201,9 тэрбум төгрөгөөр хэлэлцүүлэн Улсын Их Хурлын 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар батлуулсан. “Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны А-16 дугаар тушаал, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны А-53 дугаар тушаалуудыг тус тус батлууллаа.	100

23.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль	Төсвийн ерөнхийлөн захирагчийн батлагдсан хөтөлбөр, төсөл болон хөрөнгө оруулалтын арга хэмжээ-ний хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг батлуулах;	ХХАА-н салбарын төвлөрсөн арга хэмжээ болон хөрөнгө оруулалтын хөрөнгөөр худалдан авах бараа ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлэх;	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан байна.	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын төвлөрсөн арга хэмжээ болон хөрөнгө оруулалтын хөрөнгөөр худалдан авах бараа ажил, үйлчилгээ, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А-164 дүгээр тушаалаар батлуулсан. Худалдан авах ажиллагааг төлөвлөх тайлагнах журмын дагуу Хүнс, хөдөө аж ахуйн салбарын худалдан авах ажиллагаанд өгсөн СЯ-ны дүгнэлтэд тайлбар боловсруулан 2016 оны 01/1295 тоотой хүргүүлсэн. “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны А-20 дугаар тушаал батлуулсан.	100
Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд						
24.	Төсвийн тухай хууль	Засгийн газрын 2014-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх	Сайдаас аймгийн Засаг дарга, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргатай үр дүнгийн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих	Гэрээг хугацаанд нь байгуулан, тайланг авч нэгтгэсэн байна.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд аймгуудын Засаг дарга, Хөдөө аж ахуйн газрын даргатай 2016 онд хамтарч ажиллах гэрээ байгууллаа. 2015 оны үр дүнгийн гэрээнд ХШҮ хийлгэж дүнг салбарын удирдах ажилтны зөвлөгөөнөөр танилцуулж, гэрээний үр дүнгээр шалгарсан 3 аймгийг шагнаж урамшууллаа. Гэрээний үр дүнгээр хангалтгүй үнэлгээ авсан аймгуудын удирдлагад ажил сайжруулах үүрэг өгсөн. 2017 онд хамтарч ажиллах гэрээний төслийг боловсруулж байна.	100
25.			Сайдаас агентлаг, харьяа байгууллагын дарга, захирлуудтай үр дүнгийн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих	Гэрээг хугацаанд нь байгуулан, тайланг авч нэгтгэсэн байна.	ХХААХҮЯ-ны харьяа байгууллагын удирдлагуудтай Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу үр дүнгийн гэрээ байгуулах ажлыг зохион байгууллаа. Засгийн газрын бүтэц шинэчлэн батлагдсантай холбогдуулан харьяа газрын дарга нарын томилооны санал бэлтгэж шийдвэрлүүлэн шинээр томилогдсон бүх удирдлагатай Хөдөлмөрийн гэрээ байгууллаа. 2016 оны үр дүнгийн гэрээнд ХШҮ хийлгэх, 2017 оны үр дүнгийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж байна.	100

26.	Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн тогтоол, шийдвэрүүд	Төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх	Яамны дэргэдэх ТАЗ-ийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах	Төрийн албаны зөвлөлийн шийдвэрүүд бүрэн хэрэгжсэн байна.	Салбар зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2016 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж баталлаа. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг тухай бүрт нь батлуулж ажиллаа. Төрийн албаны зөвлөлийн Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэдэх Салбар зөвлөл 2 удаа хуралдаж, хэлэлцсэн асуудлаар зохих шийдвэрийг гаргуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллаа. Төрийн албаны зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 221 дугаартай тогтоолоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Төрийн албаны тухай хуулийн 17.1, 17.4 дэх заалтыг баримтлан төрийн жинхэнэ албан тушаалын 4 сул орон тоог нөхсөн. Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын удирдах албан тушаалын сул орон тоо, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын удирдах албан тушаалын сул орон тооны сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлээд байна.	100
27.	СЭЗ-ийн сайд, ХХАА-н сайд, НХХ-ийн сайд БСШУ-ны сайдын 2002 оны 61/А31/31/69 дүгээр хамтарсан тушаал	Салбарын мэргэжлийн ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, урамшуулах	Салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах	Мэргэшлийн зэргийг журмын дагуу олгосон байна.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох комиссыг хуралдуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Хуралдаанаар хүсэлт ирүүлсэн 65 албан хаагчдын материалыг судалж үзэн шаардлага хангасан, төрийн үйлчилгээний албанд ажиллаж буй 59 мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгуулах асуудлыг хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.	70
28.	Засгийн газрын 2014 оны 402 дугаар тогтоол	Тушаал, шийдвэр хуулийн хүрээнд хийгдэх	Захиргааны шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянах	Захиргааны шийдвэрийн эрх зүйн үндэс-лэлийг хянаж баталгаажуулсан байна.	Захиргааны шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг тухай бүр хянаж ажиллав. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын 750 тушаалын төслийн эрх зүйн үндэслэлийг хянасан.	100

29.	Засгийн газрын 2014 оны 402 дугаар тогтоол	Салбарын бодлогыг зөв тодорхойлох	Сайдын зөвлөлийн хуралдааны бэлтгэл ажлыг хангаж хуралдуулах	Сайдын зөвлөл хуралдаж шийдвэр гарсан байна.	2016 онд Сайдын зөвлөлийн хуралдааныг 2 удаа зохион байгуулж, 5 асуудал хэлэлцүүлж, 2 асуудал танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулав.	100
30.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2005 оны 71 дүгээр зарлиг	Салбарын ажилтнуудын хөдөлмөрийг үнэлэх, урамшуулах	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын ажилтнуудын шагналын асуудлыг шийдвэрлэх	Монгол Улсын цол, одон медаль, Засгийн газрын шагналаар шагнуулах хүмүүсийн тодорхойлолтыг хянаж журмын дагуу шийдвэрлэж ажиллана.	Монгол Улсын цол хүртэх, одон медалиар шагнуулахаар Аймаг, нийслэлийн Засаг дарга болон ЗДТГ-аас ирүүлсэн нэр бүхий хүмүүсийн тодорхойлолтыг хүлээн авч танилцан, давхардсан тоогоор 96 албан бичиг боловсруулж, хүн тус бүрээр санал өгч уламжиллаа. Мөн Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 95 жилийн ойг тохиолдуулан 1 албан хаагчийг Засгийн газрын хүндэт өргөмжлөл, 1 албан хаагчийг салбарын шагналд тодорхойлж холбогдох байгууллагад нь уламжилсан. 2016 оны байдлаар Хүнс, хөдөө аж ахуйн сайдын А-16, А-49, А-76, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А-02, А-26, А-49, А-58 дугаартай тушаал гарч нийт “Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр-1589, “Худалдаа, үйлдвэрийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр- 167, “Жуух бичиг”-ээр-1608 хүн тус тус шагнагдаад байна.	100
31.	Төрийн байгууллагуудын вэб сайтад тавигдах шаардлагын стандарт, Мэдээлэл холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө	Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр-рийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 283.1.4 заалт	Домайн хаяг, цахим шуудан, вэб хуудсыг тогтмол ажиллуулах, тэдгээрийн аюулгүй байдал, нууцлалыг хамгаалах, мэдээллийн сүлжээ дотоод мэдээллийн интранетийн хэвийн үйл ажиллагааг хангах	Төрийн байгууллагын стандартад нийцүүлж ажиллана. Сүлжээний хэвийн ажиллагааг хангасан байна.	2016 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар яамны цахим хуудаст шинэ мэдээ 246, тендерийн урилга 39, хууль 6, УИХ-ын тогтоол 5, ЗГ-ын тогтоол 36, Сайд, ТНБД-ын тушаал 6, цаг үеийн мэдээлэл товхимол 10, мониторингийн тайлан 37, бусад тайлан 37, Сайн малчин хөтөлбөрийн зээлийн 74 мэдээ Улаанбаатар хотын гол нэрийн зарим барааны үнийн 46 удаагийн мэдээ, төслийн хэлэлцүүлэг 12 удаа тавигдсан байна. Өдөрт дунджаар цахим хуудаст нийт 685 хүн хандаж байна. Албаны цахим шуудан хэрэглэгч 96 албан хаагчдын эрхийн зохицуулалтыг хянаж, паспортын эрхийг 21 мэргэжилтэнд сэргээж, шинээр ажилд орсон 37 мэргэжилтэнд хаяг шинээр нээж, 96 мэргэжилтэнд цахим шуудан ашиглах зөвлөгөө өгсөн. Албаны цахим шуудангаар ирсэн 87 санал,	100

					асуулганд тухай бүр хариултыг холбогдох мэргэжилтнээс авч хүргүүлсэн. Домайн хаягийн удирдлагын спанел програм ашиглан яамны цахим хуудас, цахим шуудан, файл зэрэг 3 серверийн ажиллагааг хянаж байна.	
32.	Архивын тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар	Албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөх	Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн асуудлыг эрхлэх	Хууль тогтоомж, стандартын дагуу хөтлөгдсөн байна.	Байгууллагын архиваас 2016 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж ажиллав. Энэ онд 2015 онд хөтлөгдөж дуусан 669 хадгаламжийн нэгжийг татан авч үдэж нүүрлэн бүртгэлд бүртгэсэн. Мөн салбарын хүрээнд хэрэгжиж дууссан Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөдөөгийн амьжиргаа төслийн 194 ХН, ХАА-н биржийн зохицуулах зөвлөлийн ажлын албаны 80 ХН, Цаг уурын эрсдэлийн удирдлагыг сайжруулах төслийн нэгжийн 87 ХН-ийн данс бүртгэлийг байгууллагын архивын дэргэдэх БНШК-ын хурлаар хэлэлцүүлэн татан авсан. Мөн 266 хүнд 2407 хуудас баримтанд хуулбар үнэн лавлагаа өгч, 167 байгууллага иргэдэд 981 хадгаламжийн нэгжийг бүртгэлээр олгон үйлчиллээ. 2016 онд Сайд, Төрийн нарийн бичгийн даргын “А”, “Б” 750 тушаал, 3665 албан бичгийн стандартын бүрдлийг шалган дугаар олгож, явуулсан 6765 албан бичиг, 237 өргөдлийг хүлээн авч бүртгэн түүнээс 919 бичгийг хяналтанд авснаас 878 нь шийдвэрлэгдэн хариу өгсөн байна. 2016 онд яаманд ирсэн, яамнаас явуулсан албан бичиг, Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалууд болон байнгын хадгалалтанд авсан 53, ХН-ийн 16290 хуудас баримтыг скайнарт оруулан цахим мэдээллийн сан үүсгэв.	100
33.	Жендерийн эрх, тэгш байдлын тухай хууль	Жендерийн тэгш байдлыг хангах	Салбарын хэмжээнд Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, үйл ажиллагааны явц, үр дүнгийн тайланг гаргаж, Жендерийн үндэсний хороонд хүргүүлэх	Хуулийг хэрэгжүүлж, тайлан хугацаанд хүргүүлж ажиллах	Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр болон Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2015 онд хийсэн ажлын тайланг 2016 оны 01/215 тоот албан бичгээр, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний	100

					биелэлтийг 2016 оны 01/284 тоот албан бичгээр, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны 2015 оны төлөвлөгөөний тайлан болон ХХААЯ түүний харьяа байгууллагуудын ажилтнуудын хүйсийн тэнцвэртэй байдлын судалгааг 2016 оны 01/378 тоот албан бичгээр ХАХНХЯ-нд болон Жендерийн ажлын албанд тус тус хугацаанд нь хүргүүлсэн.	
34.	Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”	Гадаад орон, олон улсын байгуулагатай эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, хамтын ажиллагааны арга хэмжээ явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх	Засгийн газар хоорондын комиссын хуралдаан болон Яам хоорондын Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэх асуудалд салбарын чиглэлээр оруулах санал боловсруулж, хэлэлцүүлэх, хуралдааны Протоколд тусгуулах, шийдвэрийг хэрэгжүүлэх	Салбараас оруулах саналыг боловсруулан Протоколд тусгуулж хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	ЗГХК-ийн хуралдаан болон тус хуралдааны дэд комиссын /Ажлын хэсгийн/ хуралд салбараас оруулах саналыг боловсруулан Протоколд тусгуулан, Протоколыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр ажилласан. Үүнд: - Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 20 дугаар хуралдаан, - Монгол, Казахстаны Засгийн газар хоорондын комиссын 7 дугаар хуралдаан, - Монгол-Болгарын ЗГХК-ын 5 дугаар хуралдаан, - Монгол-Австрийн ЗГХК-ын 5 дугаар хуралдаан, - Монгол-Финландын ЗГХК-ын 12 дугаар хуралдаан, - Монгол, Италийн Засгийн газар хоорондын холимог комиссын 1 дүгээр хуралдаан, - Монгол Литвийн ГХЯ хоорондын зөвлөлдөх уулзалт, - Монгол Нидерландын Вант Улсын Гадаад хэргийн яамд хоорондын Төрийн зөвлөлдөх уулзалт, - Монгол, Германы ЗГ хоорондын Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны ээлжит хэлэлцээр - Монгол Швейцарийн ГХЯ хоорондын зөвлөлдөх уулзалт, - Монгол, Унгарын ЗГХК-ын хуралдаан, - Монгол-Вьетнамын ЗГХК-ын 16 дугаар хуралдаан Монгол Улс Европын Холбооны хамтын ажиллагааны хамтарсан хорооны 16 хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх төлөвлөгөө болон Монгол	90
35.	Засгийн газрын 2012 оны 88 дугаар тогтоол “Засгийн газар хоорондын Монголын хэсгийн бүрэлдэхүүн” УИХ-ын 2015 оны 11 сарын 26-ны өдрийн 104 –р тогтоол		Монгол Улс болон гадаад улс, орнуудын Засгийн газар хоорондын комиссын хуралдаан болон тус хуралдааны дэд комиссын хурлын Протоколд тус салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтийг гаргах.	Салбараас оруулах саналыг боловсруулан Протоколд тусгуулж, хэрэгжилтийг хангах чиглэлээр ажилласан байна.		90

					Улс, Европын Холбооны орнуудын Засгийн газар хоорондын комиссын хуралдаан болон тус хуралдааны дэд комиссын хурлын Протоколд тус салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний төлөвлөгөөг газруудад хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
36.			Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарын гадаад улс, оронд хийсэн албан ёсны айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус салбарын чиглэлээр тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэх	Арга хэмжээний төлөвлөгөөнд орсон салбарт хамаарах заалтуудын хэрэгжилтийг гарган холбог-дох байгуула-гад цаг тухайд нь хүргүүлнэ.	Арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын чиглэлээр оруулсан заалтуудын хэрэгжилтийг гарган ГХЯ-нд цаг тухайд нь хүргүүлсэн.	90
37.	Засгийн газрын 2015 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүн”	Олон улсын байгууллагаас ХХАА-н салбарт зээл болон буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үр ашгийг дээшлүүлэх, шинээр төсөл хэрэгжүүлэх	НҮБ-ын ХХААБ, АХБ, ДБ, КОЙКА, ЖАЙКА, ШХА, ТИКА, Мерси Кор зэрэг хамтын ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагуудад хүнс, хөдөө аж ахуйн салбарын мэдээллийг хүргэж, шинэ төсөл эхлүүлэх чиглэлээр ажиллах	ОУ-ын байгууллагууд салбарын талаарх мэдээллийг цаг алдахгүй авсан байх, шинэ төслийн саналыг тавьсан байх	Европын Холбооны 4.1 сая еврогийн санхүүжилт бүхий “Монгол Улсад ажлын байр нэмэгдүүлэх төсөл: Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийн өртөгийн сүлжээг хөгжүүлэх нь” төслийн албан ёсны нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, төслийг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна. - Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслийн үйл ажиллагааг эхлүүлэв. - Швейцарын Хөгжлийн Агентлагын Хүнсний Ногооны Тогтвортой Үйлвэрлэл ба Маркетинг” төслийн хэлэлцээрийг боловсруулан төслийн үйл ажиллагааг эхлүүлэв. - ХБНГУ-ын ХХХААЯ-ны шугамаар тус салбарт хэрэгжүүлэх “Монгол-Германы тогтвортой хөдөө аж ахуй-II” төслийн баримт бичгийг боловсруулав. Японы Жайка байгууллагын шугамаар хэрэгжүүлэх “Монгол Улсын шүлхий өвчинтэй тэмцэх чадавхийг сайжруулах” төслийн саналыг Сангийн яаманд уламжлав. - Азийн хөгжлийн банкны шугамаар хэрэгжүүлэхээр “Жижиг фермерийн аж ахуйд	70

				<p>зориулсан тогтвортой ногооны аж ахуй” төслийн төлөвлөлтийн асуудлаар АХБ-ны мэргэжилтнүүдийг хүлээн авч хамтран ажиллав.</p> <p>- НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр Өвөлжилт хүндэрсэн аймгуудад яаралтай тусламж үзүүлэх болох хонь, ямааны цэцэг өвчний тархалтыг зогсоох техник туслалцааны төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллав.</p> <p>- Хонь ямааны цэцэг өвчний тархалтыг зогсоох, вакцинжуулалт хийх зорилго бүхий Техник туслалцааны төслийг боловсруулах, НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллав.</p> <p>- Бүгд Найрамдах Солонгос Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн яамны “Хөдөө Аж Ахуйн Бодлого, Хүнсний аюулгүй байдлын туршлага хуваалцах хөтөлбөр” –ийг хэрэгжүүлж эхлээд байна. Хөтөлбөрийн хүрээнд Экспортын чиг баримжаатай хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сэдвийн дагуу хамтарсан судалгаа, сургалтын хөтөлбөр, сургалт, семинарыг зохион байгуулав.</p> <p>- Японы Жайка байгууллагын шугамаар хэрэгжих “Хүнсний ногоо шууд борлуулах цэг байгуулах, хөрсний үржил шим сайжруулах төсөл”-ийг эхлүүлж, “Зөгийн аж ахуйг дэмжих, үр ашгийг нэмэгдүүлэх” төслийн техникийн уулзалтыг зохион байгуулав.</p> <p>- Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамтран ажилладаг олон улсын байгууллага, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчдөд мэдээлэл өгөх зорилгоор “Хүнс, хөдөө аж ахуйн салбарын танилцуулга”-ыг нэгтгэн англи, монгол хэл дээр боловсруулан гаргаж, дипломат төлөөлөгчдийн газруудад хүргүүлэв.</p> <p>- БНСУ-ын ХААХОНХЯ-ны захиалгаар КАПЕ байгууллагын тусламжаар “Малын ул мөрийг мөрдөн мөшгих тогтолцоог нэвтрүүлэх” төслийг хэрэгжүүлэхээр төслийн саналыг бэлтгэн хүргүүлээд байна.</p> <p>- БНСУ-ын KRC байгууллагын Олон улсын</p>
--	--	--	--	--

					боловсрол солилцооны төвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх сургалтын агуулга, хөтөлбөрийг хэлэлцэж, холбогдох сургалтын төслийг боловсруулж Солонгосын талд хүлээлгэн өгөв.	
Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд						
38.	Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 68.1, 77.1, 77.2, 77.4, 270.1, 77.5 дахь Заалт, УИХ-ын 2015 оны 108 тоот тогтоол Засгийн газрын 320, 321-р тогтоол	Мах, махан бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах зорилгоор махны нийлүүлэлтийн шинэ тогтолцоог бүрдүүлэх, Махны үйлдвэрлэлийг дэмжих зээлийн санг 100 тэрбум төгрөгт хүргэх	“Мах” хөтөлбөрийг батлуулж, махны салбарын зээлийн эргэлтийн санг бүрдүүлэх, тогтвортой ажиллуулах схем боловсруулах, хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг батлуулж, зээлийн санг үр ашигтай зарцуулсан байна.	Засгийн газрын 2015 оны 492 дугаар тогтоолоор “Мах хөтөлбөр”-ийг батлуулсан. Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 02 сарын 04-ний өдрийн 16 тоот тогтоолоор “Мах” хөтөлбөрийн хүрээнд дамжуулан олгох зээлийн хэмжээг нийт 100,0 тэрбум төгрөгөөр баталснаас эхний ээлжинд хаврын улирлын махны нийлүүлэлтийг сайжруулах, үнэ тогтворжуулах зорилгоор Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын 2016 оны 3-7 дугаар сарын хэрэгцээнд зориулан тогтвортой үнээр мах нийлүүлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулж, 10 аж ахуйн нэгжид 25,0 тэрбум төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн. Үүнээс тус яамтай бодлогын гэрээ байгуулсан 9 аж ахуйн нэгжээс 4 аж ахуйн нэгжид 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдөр нийт 11,8 тэрбум төгрөгийн зээл арилжааны банкнаас олгогдсон. Хөгжлийн банкаас ирүүлсэн 2016 оны 2/670 тоот албан бичгээр “Мах” хөтөлбөрийн хүрээнд олгох үлдэгдэл 75,0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэж зээл олгоход хүндрэлтэй байгаа тухай мэдэгдсэн болно. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А-119 дугаар тушаалаар “Мах” хөтөлбөрт оролцогч аж ахуйн нэгжийн нөөцөлсөн махны бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалт болон чанар, аюулгүй байдалд хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулж, Хөгжлийн банкнаас “Мах” хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлэнд хамрагдан тус яамтай байгуулсан бодлогын гэрээний дагуу Улаанбаатар, Дархан хотын хүн амын 2017 оны хаврын улирлын хэрэгцээнд тогтоосон үнээр мах нийлүүлэх аж ахуйн	70

					нэгжүүдийн агуулах дахь нөөцөлсөн махны бүрдүүлэлт, тоо хэмжээ, агуулахын үйл ажиллагаа, холбогдох бичиг баримтад хяналт шалгалтыг Хөгжлийн банк, арилжааны банк, Монголын махны холбооны төлөөллийн хамт хийж гүйцэтгэв.	
39.			Хот суурин газруудад хаврын улирлын нөөцийн мах бэлтгэх, хадгалах, худалдаалахад олгох урамшууллын 2014-2015 оны санхүүжигдээгүй үлдэгдлийг хууль журмын хүрээнд олгох асуудлыг зохион байгуулах	Урамшууллын үлдэгдлийг тооцож олгосон байна.	Гэрээний дагуу хамтран ажилласан МХЕГ, ОБЕГ-ын ирүүлсэн тайлан, гэрээ дүгнэсэн акт, нөөцийн махны санхүүжилтийн гэрээ, санхүүжилтийн гэрээ дүгнэсэн тэмдэглэлийг тус тус үндэслэн 2014-2015 оны санхүүжигдээгүй нөөцийн махны урамшууллын зардлыг 2016 оны төсөвт тусгуулан батлуулж, батлагдсан 10,0 тэрбум төгрөгийг хууль журмын хүрээнд нийцүүлэн олгох асуудлыг зохион байгуулсан.	100
40.	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 4.1.13	Шим тэжээллэг хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Хүнсний хууль эрх зүйн хорооны "Утсан загас, угаж-хатаасан загас САС 311:2013" стандартыг орчуулж, хэлэлцүүлэх, загасны хэрэглээг нэмэгдүүлэх талаар сурталчлах	Стандартыг орчуулж, үндэсний стандартын төсөл боловсруулсан байна.	Загасны мах, загасан бүтээгдэхүүний техникийн зохицуулалт боловсруулах, Хүнсний хууль эрх зүйн хорооны Утсан загас, угаж хатаасан загас САС 311:2013 стандартыг орчуулав.	70
41.	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 4.1.4 ба 4.1.11 дэх заалт	Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэмжээг 2020 онд 100,0 мян.тн-д хүргэх	БНХАУ-д мах экспортлоход тавигдах эрүүл ахуй, ариун цэвэр, техникийн болон худалдааны нөхцөл, шаардлагын талаар гарын авлага боловсруулж, хэвлүүлэх, тараах	Гарын авлагыг боловсруулж, хэвлүүлэн, түгээсэн байна.	Махны үйлдвэрлэл, экспортод тавигдах тенологи, эрүүл ахуйн шаардлага, мал эмнэлгийн хяналтын талаар гарын авлага боловсруулан, хэвлүүлж, тараав.	100
42.	Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 242 дахь заалт	Органик хөдөө аж ахуйг хөгжүүлэх эдийн засаг, санхүү банкны тааламжтай орчныг бүрдүүлж, Органик монгол үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Органик хүнсний тухай хуулийн төслийг холбогдох Байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэх	Хуулийн төслийг БХ-ны хурлаар хэлэлцүүлсэн байна.	УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2016 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар Органик хүнсний тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж, УИХ-ын 2016 оны хаврын ээлжит чуулганы 2016 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Органик хүнсний тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж батлагдлаа.	100
43.	МУ-ын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.5.3 дахь заалт Хүнсний тухай	2016 онд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний дагуу сонгон шалгаруулах	Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион байгуулах	Сонгон шалгаруулалтыг хууль, журамд нийцүүлэн зохион байгуулсан байна.	- 2016 онд 155,5 мянган тонн хүнсний улаанбуудай импортлох квотын зөвшөөрөл олгохоос нийт 26 аж ахуйн нэгжид 152,6 мянган тонн улаанбуудай импортлох зөвшөөрөл олгосон байна. - 2016 онд 40300 улаанбуудайн гурил импортлох зөвшөөрөл олгохоос Төрийн нарийн бичгийн	100

	хуулийн 6.7, 6,8 дахь заалт,	ажлыг зохион байгуулах			<p>даргын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А-467 дугаар тушаалаар нийт 65 аж ахуйн нэгжид 40300 тн улаанбуудайн гурил импортлох зөвшөөрөл олгосон байна. Нийт гурилын квотоос төв болон баруун бүсээс бусад бүсэд нийт квотын 74%, баруун бүсийн аймгуудад нийт квотын 26%-ийг тус тус олгосон байна.</p> <p>- Махны экспортын тоо, хэмжээг нэмэгдүүлэх, холбогдох ажлыг шуурхай зохион байгуулах тухай Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2015 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын шийдвэр, Хүнс, хөдөө аж ахуйн Сайд, Төрийн нарийн бичгийн даргын холбогдох тушаал, шийдвэрийг үндэслэн 2016 онд хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжүүдэд тухай бүр зохих экспортын зөвшөөрлийг олгон ажиллаа.</p> <p>- 2016 оны эхний 11 дүгээр сарын байдлаар ОХУ-д “Баатарууд тэнгэр” ХХК, “Дархан меат фүүдс” ХХК, “Эй Эн Ди Эм” ХХК, “Соотон” ХХК, БНХАУ-д “Завхан хүнс” ХХК, “Монгол мах экспо” ХХК, “Грийн гресс ланд” ХХК, “Монгол Эко мах” ХХК-иуд үйлдвэрийн аргаар бэлтгэсэн 6,6 мянган тонн малын махыг экспортолсон байна.</p> <p>- Дээд зэрэглэлийн үхрийн мах импортлох 2000 тн квотын зөвшөөрөл олгохоос хүсэлт ирүүлсэн 4 аж ахуйн нэгжид 318 тонн үхрийн мах импортлох зөвшөөрөл олгосон байна.</p> <p>- 2016 онд 4476 тн хуурай сүү импортлох зөвшөөрөл олгохоос Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 04 дугаар сарын 05-ны өдрийн А-141 дугаар тушаалаар нийт 12 аж ахуйн нэгжид 4476 тонн хуурай сүү импортлох зөвшөөрөл олгосон байна.</p>	
44.	Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 4.1.14 дэх заалт	Нийтийн хоолны үйлдвэрлэлд зэрэглэл тогтоох	Хоолны газрын ангилал зэрэглэл MNS 4946:2005 стандартын шинэчилсэн төслийг боловсруулан, СХЗГ-ын Техникийн зөвлөлөөр хэлэлцүүлэх	Төслийг боловсруулж, СХЗҮТ-д хүргүүлсэн байна.	<p>“Хоолны газрын ангилал зэрэглэл. MNS 4946:2005 стандартыг шинэчилэн боловсруулах” Зөвлөх үйлчилгээний тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч уг ажлыг санхүүжүүлэх боломжгүй болсон. Стандартын төслийг боловсруулан, төсөлд санал авч байна.</p>	70

45.	Хүнсний тухай хуулийн 16.2 дахь заалт	Баяжуулагч бэлдмэл, хүнс-ний нэмэлт, өсгөврийн хө-рөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүрт-гэх, нийтийн хэрэгцээнд гаргах журмыг хүнсний асуу-дал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг улсын бүртгэлд бүртгэх, хяналт тавих журам боловсруулж батлуулах	Журам батлагдсан байна.	“Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг улсын бүртгэлд бүртгэх, хяналт тавих” журам боловсруулах Зөвлөх үйлчилгээний тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч уг ажлыг санхүүжүүлэх боломжгүй болсон. Журмын төслийг эцэслэн боловсруулан ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон.	90
46.	Хүнсний аюулгүй байдал хөтөлбөр, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7.2 дахь заалт	Зохистой дадлыг хялбар-шуулан нэвтрүүлэх зааврыг хүнсний болон эрүүл мэндийн асуудал эрхэл-сэн ТЗ-ны төв байгууллага хамтран батална.	Хүнсний үйлдвэрүүдэд эрүүл ахуйн болон үйлдвэрийн зохистой дадал нэвтрүүлэх хялбаршуулсан зааврыг боловсруулж хэлэлцүүлэх, батлуулах	Зааврыг боловсруулан батлуулсан байна.	Хөдөө аж ахуйн, эрүүл ахуйн, үйлдвэрлэлийн зохистой дадлыг тус тус хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төслийг боловсруулсан. Зохистой дадлыг нэвтрүүлэх зөвлөмж, арга замын талаар салбарын аж ахуйн нэгжүүдийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулав.	70
47.	“Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийн 10.1.2 дахь заалт	Эдийн засаг, санхүү, бизнесийн таатай орчин бүрдүүлэх замаар хүн амыг аюулгүй баталгаатай, эх орны үйлдвэрийн хүнсээр хангах	”Намрын ногоон өдрүүд 2016” нэгдсэн арга хэмжээг шинэлэг хэлбэрээр зохион байгуулах	Борлуулалт 10 хувь нэмэгдсэн байна.	Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн уриан дор "Намрын ногоон өдрүүд -2016" нэгдсэн арга хэмжээг 09 дүгээр сарын 14-20-ны өдрүүдэд Мишээл экспо төвд зохион байгуулав. Нэгдсэн арга хэмжээний үеэр "Эрүүл Монгол хүнс" үндэсний хүнс үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаа, "Алтан намар" шинэ ургацын төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний өргөтгөсөн худалдааг зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд нийт 17 аймаг, нийслэлийн дүүргүүдийн 100 гаруй хүнс үйлдвэрлэгч, төмс, хүнсний ногоо тариалагч, малчдын хувцас үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, 306 ногоочин, 933 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн, 24 нэр төрлийн хүнсний ногоо, төмс, жимс, жимсгэнэ, модны суулгац, зөгийн бал зэрэг бүтээгдэхүүнээр оролцож, 1,0 тэрбум орчим төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. Түүнчлэн үзэсгэлэнгийн үеэр хүнсний төрөл бүрийн бүтээгдэхүүний онцлогийг илэрхийлсэн "Эх орны сүү-эрүүл хүнс", "Ногоон	100

					хүнс-Эрүүл амьдрал", "Органик хөдөө аж ахуйг дэмжих", "Дэлхийд танигдсан Монгол амт", "Эрүүл хүнс-таны сонголт" зэрэг өдөрлөгүүдийг хэрэглэгчдийн дунд, амталгаа явуулах, хөгжөөнт уралдаан тэмцээн зохиох азтанг шалгаруулж, дуудлага худалдаа, хоолны үзүүлбэр зохион байгуулах зэргээр бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд сурталчилж, органик бүтээгдэхүүнийг ашиглан хоол бэлтгэх шоу, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, хадгалах технологийн зөвлөмж өгөх, эрүүл хүнсний ач холбогдол, эрүүл хооллолтын үндсэн зарчмуудын талаарх сурталчилгаа материалыг олон нийтэд түгээх зэрэг олон онцлог арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.	
Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд						
48.	“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”.1.1.	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах, бэлчээрийн мал аж ахуй эрхлэн хөтлөх аргыг боловсронгуй болгон хөгжүүлнэ.	Тэргүүний малчдын улсын зөвлөгөөнийг зохион байгуулах	Тэргүүний малчдын улсын зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.	Тэргүүний малчдын улсын зөвлөгөөнийг 2016 оны 03 дугаар сарын 17-19-нд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Зөвлөгөөнд 22 аймаг, нийслэл, 330 сумаас төлөөлөн нийт 900 малчид, 50 орчим мал аж ахуйн салбарын мэргэжилтэн нар оролцсон байна. Мөн зөвлөгөөнд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, хөдөө аж ахуйн салбарын сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын 50 гаруй төлөөлөл урилгаар оролцож санал бодлоо солилцов. Зөвлөгөөний үеэр нэгдсэн хуралдааныг зохион байгуулж орон нутгаас ирсэн малчид, төлөөлөгчдийн санал хүсэлтийг сонсож, мал аж ахуйн салбарын талаар үзэсгэлэн гаргах ажлыг зохион байгуулав. Мөн салбар хуралдааныг “Сайн малчин-малчдын нийгмийн асуудал”, “Мал-үндэсний баялаг”, “Эрүүл мал-эрдэнэ”, “Бэлчээр-ногоон алт” гэсэн 4 чиглэлээр зохион байгуулав. Малчдын санал хүсэлтийг үндэслэн малчин олон түмэнд хандсан нэгдсэн уриалга гаргасан бөгөөд уриалгыг аймаг, орон нутагт хүргүүлж, хэрэгжилтийг орон нутагтаа хамтран зохион байгуулан ажиллаж байна.	100

49.	“Монгол мал” үндэсний хөтөлбөр.3.2.2.	Гойд ашиг шимтэй малын удмын санг хамгаалах, зохистой ашиглах ажлыг зохион байгуулна.	“Шилмэл мал-2016” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	“Шилмэл мал-2016” үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан, оролцоо, үр дүнг нэмэгдүүлсэн байна.	“Шилмэл мал-2016” үзэсгэлэн худалдааг энэ оны 09 дүгээр сард Улаанбаатар хотод зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байсан болно. Мал эмнэлэг, үржлийн газраас 2016 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 409 дугаартай албан бичгээр Улсын хэмжээнд 2016 онд мал, амьтны гоц халдварт өвчний дэгдэлт ихтэй байгаа тул малын шилжилт хөдөлгөөн хийх боломжгүй гэдгийг мэдэгдсэн тул “Шилмэл мал-2016” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах арга хэмжээ хийгдээгүй бөгөөд төлөвлөсөн зардлыг нь өөр арга хэмжээнд зарцуулахаар шийдвэрлэсэн.	70
50.	“Монгол мал” үндэсний хөтөлбөр.3.2.2, Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоол	Малын удмын санг хамгаалж, биотехнологийн дэвшилтэт аргыг нэвтрүүлэн, малын бүтээмжийг нэмэгдүүлнэ.	Малын удмын сангийн үндэсний төвийн шинэ цогцолборын барилгыг дуусгах ажлыг холбогдох байгууллага, газартай хамтран зохион байгуулах	Цогцолбор барих ажлыг бүрэн дуусгаж хүлээн авсан байна.	Малын удмын сангийн үндэсний цогцолборын /Дархан-Уул, Хонгор сумын нутаг дахь/ инженерийн иж бүрэн шугам сүлжээ болон барилга угсралтын эхний ээлжийн ажлын гүйцэтгэл 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 98.0 хувьтай байна. Үүнд: Цогцолборын баригдаж байгаа нийт 16 барилгаас Үйлдвэрлэлийн барилгын ажил 96.0, Уурын зүүхны барилгын ажил 76.0, Тэжээл үйлдвэрлэх цехийн барилгын ажил 69.0 хувьтай, үлдсэн 13 барилгын ажлын гүйцэтгэл бүрэн дуусаж, зарим гадна, дотор заслын ажлууд үлдсэн байна. - Гэрээт ажлын санхүүжилт болон цэвэр усны хангамжийн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотойгоор гүйцэтгэгч компанитай дутуу ажлыг гүйцээх ажлын графикийг тохирсоны үндсэн дээр ерөнхий захиалагч ХХААХҮЯ-наас гүйцэтгэгч “НАБСАН” ХХК-тай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан гэрээний хугацааг сунгахаар шийдвэрлээд ажиллаж байна.	90
51.	“Монгол мал” үндэсний хөтөлбөр.3.2.1	Монгол малын ашигтай онцлог шинж чанарыг тухайн үүлдэр, омог, хэвшлийн баталгаажсан цөм сүргээр бататган	Орон нутагт үржүүлж сайжруулагчаар ашиглаж байгаа нутгийн болон батлагдсан омгийн малыг шинээр омог, үүлдэрээр батлуулах зорилгоор явуулсан малын үржил селекцийн ажилд хянан магадлагаа хийх, батлуулах ажлыг зохион байгуулах.	Ховдын Сутай омгий хонь, Алтайн улаан үүлдрийн хэсгийн ямаа, Баянхонгорын Ламын гэгээний	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвлөлийн 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар Хэнтий аймгийн Галшар омгийн адууг, Ховд аймгийн Алтайн улаан үүлдрийн хэсгийн ямааг үүлдрээр, Говь-Алтайн Дэлгэрийн улаан ямааг Алтайн улаан үүлдрийн ямааны Д хэвшлээр, Баянхонгор аймгийн Бөмбөгөрийн улаан ямааг	100

		сайжруулж, удам зүй, сонгон үржүүлгийн ажлын шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж, биологийн боломжийг бүрэн ашиглана.		хүрэн тэмээ, Бөмбөгөрийн улаан ямаа, Хэнтийн Галшар адуунд явуулсан үржлийн ажилд хянан магадлагаа хийж сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн байна.	омгоор тус тус баталсан. -Ховд аймгийн Сутай омгийн хонинд явуулсан үржлийн ажилд хянан магадлагаа хийх ажлын хэсэг энэ оны 06 дугаар сард Ховд аймгийн Дарви суманд ажиллаж сайдын зөвлөлийн хуралдаанаар асуудлыг хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна. -Баянхонгорын Ламын гэгээний хүрэн тэмээнд явуулсан үржлийн ажилд хянан магадлагаа хийж байна. -Хөвсгөл аймгийн “Эрчим” омгийн хар ямаанд явуулсан үржлийн ажилд хянан магадлагаа хийх ажлын хэсэг энэ оны 11 дүгээр сарын 10-15-ны өдрүүдэд, Баянхонгор аймгийн Баянлиг суманд үржүүлж байгаа тэмээнд явуулсан үржил селекцийн ажилд хянан магадлагаа хийх ажлын хэсэг Хөвсгөл аймгийн Төмөрбулаг суманд, 11 дүгээр сарын 16-23-ны өдрүүдэд тус тус ажиллан судалгаа хийж, холбогдох дүгнэлтийг гаргахаар ажиллаж байна.	
52.	Усны тухай хуулийн 10.1.3	...журам, зааврыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, батлах;	“Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах.	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулж батлуулсан байна.	“Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам”-ын төслийг боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллага, аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газраас санал авч нэгтгэн журмын төслийг эцэслэн боловсруулж байна.	70
53.	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжааг зохион байгуулна	Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцогчдын чадамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.	Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцогчдыг хөнгөлөлттэй зээл олгож дэмжсэн байна.	Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд малчдын хоршоодыг оролцох чадамжийг нэмэгдүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах баримт бичгийн төслийг боловсруулж бэлтгэсэн боловч “Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хууль батлагдсантай холбогдуулан “Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А-16 дугаартай тушаалаар “Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцогчдын чадамжийг нэмэгдүүлэх” арга хэмжээг хасаж хүчингүй болгосон тул хэрэгжээгүй болно.	30

54.	“Монгол мал” үндэсний хөтөлбөр.3.4.1.6	Бэлчээрт хөнөөл учруулдаг мэрэгч амьтад, шавьжтай байгаль орчинд халгүй, дэвшилтэт арга, технологи ашиглан тэмцэх замаар мал аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулна.	Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй мэрэгч амьтан, шавьж (үлийн цагаан оготно, царцаа гэх мэт)-тай тэмцэх арга хэмжээг зохион байгуулах	Судалгааны дүнг үндэслэн 2016 онд үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх аймаг, сумын тоо, талбайн хэмжээг тогтоосон байна. Микробиологийн аргаар 110.0, энгийн механик аргаар 415.0 мянган га-аас доошгүй талбайд үлийн цагаан оготно-той тэмцэх ажлыг гүйцэтгэнэ. 13000 литр ургамал хамгаалах бодис худалдан авч, орон нутагт хуваа-рилан хүргүүлсэн байна. Бэлчээрт хө-нөөл учруулж буй царцаатай 65.0 мянган га-аас доошгүй талбайд химийн аргаар тэмцсэн байна.	“Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж буй мэрэгч амьтан, царцааны тархалт, хөнөөлийн тодотгох судалгаа хийлгэх тухай” гэрээг 2016 онд 17.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй байгуулав. Судалгааны дүнг үндэслэн дараах арга хэмжээг 2016 онд зохион байгуулж хэрэгжүүлсэн. Үүнд: - Микробиологийн аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг 2016 онд нийт 2 аймгийн 5 сумын 110.0 мянган га бэлчээрийн талбайд 83.0 хувийн үр дүнтэй гүйцэтгэсэн байна. - Энгийн механик аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг 2016 онд нийт 10 аймгийн 59 сум, отрын 2 бүс нутгийн 415.0 мянган га бэлчээрийн талбайд 80-аас дээш хувийн үр дүнтэй гүйцэтгэсэн байна. - Царцаатай тэмцэх ажлыг 2016 онд нийт 2 аймгийн 11 сумын 45.1 мянган га талбайд 91.7 хувийн үр дүнтэй гүйцэтгэсэн байна.Энэ ажилд шаардагдах 13000 литр ургамал хамгаалах шингэн бодисыг худалдан авч, технологийн хугацаанд нь 3 аймагт хуваарилан хүргүүлсэн. Эдгээр ажлын үр дүнд нийт 570.1 мянган га бэлчээрийн талбайг үлийн цагаан оготно, царцааны хөнөөлөөс хамгаалах ажлыг орон нутагтай хамтран зохион байгуулж, бэлчээрийн даац багтаамжийг нэмэгдүүлсэн байна.	100
55.	“Монгол мал” үндэсний хөтөлбөр.3.3.3.	Малын эмийн чанар аюулгүй байдлыг хангах, малын эм, эмнэлгийн хэрэгслийн импортлох, үйлдвэрлэх ажиллагааг олон улсын стандартын түвшинд хүргэнэ.	Малын эмийн салбар зөвлөлийн ажлыг зохион байгуулах	Малын эмийн салбар зөвлөлийн хуралдааныг 4-өөс доошгүй удаа зохион байгуулж, асуудлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Энэ онд батлагдсан төлөвлөгөөний дагуу Малын эмийн салбар зөвлөлийн ээлжит хуралдааныг 4 удаа, ээлжит бус хуралдааныг 1 удаа, нийт 5 удаагийн хуралдааныг зохион байгуулж холбогдох асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлэж ажиллав.Үүнд: Малын эм улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт гаргасан эм ханган нийлүүлэх 21 байгууллагын 13 улсын 81 төрлийн эмийг хэлэлцэж, 63 төрлийн эмийг шинээр эмийн улсын бүртгэлд бүртгэж,	100

					шаардлага хангаагүй 18 эмийг буцааж, 17 эмийн бүртгэлийн хугацааг сунгаж хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллав. Мөн цаг үеийн бусад асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв. Малын эмийн улсын бүртгэлийн санд шинээр бүртгүүлсэн эмийн материалыг архивийн нэгж болгон хадгалж, эмийн хувийн хэргийг баяжуулалт хийв. Шинээр бүртгэгдсэн эмийн мэдээллийг яамны вэб хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулав.	
56.	Монгол мал үндэсний хөтөлбөрийн 3.3.3		Зайлшгүй шаардлагатай малын эмийн жагсаалтыг шинэчлэн батлуулах	Зайлшгүй шаардлагатай малын эмийн жагсаалтыг шинэчлэн батлуулсан байна.	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2009 оны 261 дүгээр тушаалаар батлагдсан Мал эмнэлгийн Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг шинэчлэн батлуулах зорилгоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зайлшгүй шаардлагатай эмийн талаарх үзэл баримтлалд тулгуурлан манай орны мал, амьтны өвчлөлийн байдал, мал эмнэлгүүдийн хэрэгцээнд тохируулан жагсаалтын төслийг боловсруулан холбогдох мэргэжлийн байгуулагуудаас санал авч сонгох ажлыг зохион байгуулж байна.	70
57.	“Монгол мал” хөтөлбөрийн 3.4.1.2.	Бэлчээрийн харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг бүр-дүүлэх, нийт бэлчээрийн 10-аас доошгүй хувийг улс, аймаг, сумын отрын бүс нутаг, нөөц бэлчээр болгон хамгаалалтанд авч, цаг хүндэрсэн үед ашиглах боломжийг бүрдүүлнэ.	Аймаг дундын отрын бэлчээрийг өргөтгөх судалгаа хийх, дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулах	Шинээр байгуулах аймаг дундын отрын бүс нутгийн талаар судалгаа хийж, дүгнэлт гаргуулсан байна.	Хөвсгөл аймгийн 35000 га бэлчээрт аймаг дундын отрын бүс нутгийн судалгаа хийх ажлын хэсэг байгуулах тухай Сайдын 2016 оны А-56 дугаар тушаал, Аймаг дундын отрын бэлчээрийн судалгааг санхүүжүүлэх тухай ТНБД-ын 2016 оны А-242 дугаар тушаал тус тус гаргуулсан. Ажлын хэсэг 2016 оны 11 дүээр сарын 10-15-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Төмөрбулаг сумдад албан томилолтоор ажиллаж, отрын бүс нутаг болгох санал ирүүлсний дагуу дээрх сумдын нутгийн заагт орших 35.000 га бэлчээрийг улсын тусгай хэрэгцээнд авахад шаардлагатай багийн ИНХ, сумын ИТХ-ын тогтоол шийдвэрийг гаргуулахаар зохион байгуулан ажиллаж байна.	90
58.	Засгийн газрын 2007 оны 187, 2014 оны 299 дүгээр тогтоол	Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бэлчээрийн хилийн заагийг тэмдэгжүүлнэ	Ховд аймаг дахь баруун бүсийн аймаг дундын отрын Баян нурууны бэлчээрийн хилийн заагийг тэмдэгжүүлэх, тусгай хэрэгцээний дундын отрын бэлчээрийн судалгаа, мэдээлэл бэлтгэх ажлыг зохион	Ховд аймаг дахь Баян нурууны 105.2 мян. га бэлчээрт тэмдэгжүүлэлт	“Отрын бэлчээр нутгийн хил заагийг тэмдэгжүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгох” тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах тухай Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А-145 дугаар	100

			байгуулах	хийг, судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргасан байна.	тушаалын дагуу “Отрын бэлчээр нутгийн хил заагийг тэмдэгжүүлэх ажил гүйцэтгэх” гэрээг байгуулж, нийт 20ш самбарыг Баян нурууны отрын 105.2 мянган га бэлчээрт байршуулсан.	
Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд						
59.	“Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийн 14.5. Монгол Улсын Засгийн газрын 2015-08-03-ны өдрийн 320 дугаар тогтоол.	“Тол нэрийн бараа бүтээг-дэхүүний үнэ тогтворжуулах” дунд хугацаа-ны хөтөлбөрийн “хүнсний зорь, агуула-хыг нэмэгдүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор аж ахуйн нэгжүүдэд олгосон 33,0 тэрбум төгрөгийн зээлийн хугацааг үнэ тогтворжуулах нөх-цөлтэйгээр 1 жилээр сунгах	Аудитын ерөнхий газрын дүгнэлт, бодлогын гэрээний биелэлт, үнэ тогтворжуулах зорилгоор хэрэгжүүлж байгаа ажлын үр дүн зэрэг үзүүлэлтийг үндэслэн зээлийн гэрээ сунгах аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах	Шаардлагад нийцсэн аж ахуйн нэгжүүдийн дүнг сайдад танилцуулж гэрээ сунгах асуудлыг шийдвэрлэсэн байх. Гэрээг сунгахдаа үнэ тогтворжуулах үйл ажиллагааны нөхцлийг баталгаажуулж оруулсан байх.	Засгийн газрын 2015 оны 320 дугаар тогтоолд заасны дагуу 14 аж ахуйн нэгжийн 33,0 тэрбум төгрөгийн зээл төлөх хугацааг нэг жилээр сунгуулахаар Хөгжлийн банк болон харилцагч арилжааны банкуудад хүргүүлсэн.	70
60.	Монгол Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоол. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, 1.3.5	Хураалтын дараах боловсруулалтын чанарыг сайжруулах, таримал бүтээгдэхүүний хадгалалт борлуулалтын урсгалыг тодорхойлох боломжийг бүрдүүлэх	Аймаг, нийслэл, сум, дүүрэгт байгаа аж ахуйн нэгжүүдийн үтрэм, элеватор, зорь, агуулахын тоо, багтаамж, хийцийн төрөл бүхий үзүүлэлтээр тооллого, аттестатчиллыг явуулах;	Үтрэм, элеватор, зорь, агуулахын аттестатчилал, тооллогыг шинэчлэн явуулсан байна.	Ургац хүлээн авах элеватор, агуулахын ариутгал халдваргүйжилтийг хийлгэх, Мэргэжлийн хяналтын албаар дүгнэлт гаргуулах ажлыг ТЭДС-тай хамтран хэрэгжүүлж, ТЭДС-ийн Хөтөл, Булган, Угтаал, Сэлэнгэ, Хархорин салбаруудыг бүрэн хамруулав. Үүнд: - Дархан салбарын элеваторын ариутгал шаардлага хангаагүй. - Улсын хэмжээнд нийт 549,3 мянган тонны багтаамжтай 23 элеватортай бөгөөд үүнээс ТЭДС-д 182,0 мянган тонн, гурилын үйлдвэрүүдэд 275,3 мянган тонн, үр тарианы аж ахуйд 110,0 мянган тонны багтаамжтай элеватортай байна. - Төмс, хүнсний ногооны зорийн багтаамж 197,5 мянган тонн байна.	70
61.	УИХ-ын 2012 оны 37 дугаар тогтоол	93.7. Төмсний үрийг шинэч-лэх ажлыг эрчимжүүлж 500.0 мянган ширхэг бичил булцуу үйлдвэрлэнэ.	Хаврын тариалалтаар 45.0 мянган ширхэг булцуу тарих, арчлах, хураах, хадгалах, 2016 оны тариалалтад шилжүүлэх ажлыг зохион байгуулах	150.0 мянган ширхэг булцуу үйлдвэрлэсэн байна. Үрийн хэрэгцээг 30 хувь хангана.	Улсын төсвийн 50,0 сая төгрөгт тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 50,0 мянган ширхэг бичил булцуу үржүүлж, 35,2 мянган тн төмсний элит үрийг 2017 оны 05 дугаар сард авах гэрээг Элит үр ХХК-тай хийв.	70

62.	Таримал ургамлын үр, сортын тухай хууль	Орон тооны бус салбар зөвлөлийн хурал зохион байгуулах.	Улсын сорт сорилтын зөвлөлийн хурлыг зохион байгуулах, сортын жагсаалт хэвлүүлж, нийтэд мэдээлэх	УССЗ-н хурлыг зохион байгуулж сортуу-дын жагсаал-тыг нэгтгэж, 2016 оны үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлын бэлтгэл хангасан байна. Сортын жаг-саалтыг хэвлүүлж түгээсэн байна.	Улсын сорт сорилтын зөвлөлийн хурлыг 12 дугаар сарын 14- нд зохион байгуулав. 2016 онд ирээдүтэй болон нутагшсан сорт, импортоор орж ирсэн таримал ургамлын үрийн мэдээллийн талаар холбогдох газраас санал авч жагсаалтыг нэгтгэв.	70
63.	ЗГ-ын 2010 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Чацаргана” хөтөлбөр	Чацаргана, жимс жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх, боловсруулалтыг сайжруулах, нэмэгдсэн өртийн сүлжээ байгуулах	Чацаргана, жимс жимсгэний аж ахуй байгуулах, боловсруулах үйлдвэр байгуулах, сайжруулахад Азийн хөгжлийн банкны урт хугацаатай зээлийн дэмжлэгт хамруулах, нэмэгдсэн өртгийн сүлжээ байгуулах	Чацарганы 200 га талбай бүхий жимст цэцэрлэгийн аж ахуй шинээр байгуулагдаж, боловсруулах үйлдвэрлэл нэмэгдэж, бүтээгдэхүүний нэр төрөл, чанар сайжирна.	Чацарганы суулгац зээлээр олгох ажлыг ТЭДС-аар дамжуулан 6 аймгийн 12 иргэн, аж ахуйн нэгжид 31,6 мянган ширхэг суулгац зээлээр олгож, тариалалтыг 25,3 га талбайгаар нэмэгдүүлэв. Жимс жимсгэний аж ахуй эрхлэгчдэд тус бүр нь 6,0га услах 20 иж бүрдэл усанд хэмнэлттэй, дэвшилтэт дуслын усалгааны төхөөрөмж нийлүүлж, санхүүжилтийн 50 хувийг олгуулав. Чацарганы гадаад зах зээл, бүтээгдэхүүний судалгаа хийх ажлыг Зах зээл, бэлчээрийн менежмент төслийн санхүүжилтээр хийлгэв. “Жимс жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийг Жимс жимсгэнэ судлалын профессорын багтай хамтран боловсруулав.	90
64.	Засгийн газрын 2013 оны 141 дүгээр тогтоол	Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, жилийн турш хүнсний ногооны хангамжийг сайжруулах	Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөнөөс санхүүжүүлж буй “Өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах” төслийн хэрэгжилтэд хяналт тавих, Азийн хөгжлийн банкны урт хугацаатай зээлд хамруулж хүлэмжийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулагдаж шинэ ургацын гүзээлзгэнэ, чинжүү, өргөст хэмх, улаан лоолийн үйлдвэрлэл, хангамж жилийн турш тогтворжино.	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх “ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих” төслийн тендерт тус бүр 1,8 га талбай бүхий хүлэмж байгуулах тендер шалгаруулалт зохион байгуулж байна. “Хүлэмжийн ногооны амт” үзэсгэлэн худалдааг 2016 оны 06 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Барилгачдын талбайд зохион байгуулав. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих зээлийн төсөлд хүлэмжийн аж ахуй, чацарганы аж ахуйг хамруулахаар шийдвэрлүүлж, төслийг хэрэгжүүлэх чиглэлээр санал боловсруулж, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл, зөвлөмж хүргүүлэв. Эдийн засгийг тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд	90

					5 га талбай бүхий иж бүрэн цогцолбор хүлэмж байгуулах төсөл боловсруулж оруулаад байна. Чингис бондын санхүүжилтээр хэрэгжсэн “Хүлэмжийн аж ахуй байгуулах” төслийн санхүүжилт авсан Улаанбаатар хот орчмын 10 аж ахуйн нэгжид хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.	
65.	ЗГ-ын 2013 оны 268 дугаар тогтоол	“Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах	“Алтан намар-2016” шинэ ургацын үзэсгэлэн, худалдаа, сургалт зохион байгуулах	Үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан байна.	“Алтан намар -2016” үзэсгэлэн худалдаанд 17 аймгийн 29 сум, нийслэлийн 5 дүүргийн нийт 300 ногоочин, 28 аж ахуйн нэгж, хоршоо, 4 төсөл төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, ногооны үр, таримал болон байгалийн жимс, чимэглэлийн модны суулгац, эмийн ургамал бүтээгдэхүүнээр оролцов. Үзэсгэлэнгийн үеэр оролцогчид 420,0 тонн төмс, 24 нэр төрлийн 680,0 тонн хүнсний ногоо, 26000 шил нөөшилсөн ногоо, 2,2 тн зөгийн бал, 150 кг байгалийн эмийн ургамал, 0,8 тонн чацаргана, 0,1 тонн үхрийн нүд, 10,0 тонн байгалийн жимс /аньс, чацаргана, нэрс, долоогоно, нохойн хошуу, хад, мойл/ 6000 ширхэг чацарганы суулгац, 5000 ширхэг үхрийн нүдний суулгац, 1200 ширхэг улаалзгана, 1500 ширхэг интоор, 500 ширхэг гүйлс, 1000 ширхэг чимэглэлийн суулгац, 140 ширхэг тасалгааны цэцэг зэрэг бүтээгдэхүүнээр нийт 728.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Ногоочдын худалдааг дэмжих борлуулах зорилгоор Нийслэлийн Засаг даргатай “Санамж бичиг” байгуулж, 434 худалдааны цэгт 11 дүгээр сарын 25-ныг хүртэл борлуулалт хийв.	100
Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд						
66.	Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.1, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол		Яамны 2015 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Үнэлгээний дүнг ЗГХЭГ-т хүргүүлсэн байх	Хүнс, хөдөө аж ахуйн яамны 2015 оны үйл ажиллагааны үр дүнг холбогдох журмын дагуу 4 багц, 14 үзүүлэлтээр дүгнэв. Ерөнхий үнэлгээ 84.02 хувь буюу 4.2 оноогоор дүгнэгдсэн. Үүнд: - Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт – 83,2% - Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлт – 82,3% - УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж,	100

				<p>Засгийн газрын шийдвэрийн биелэлт – 85,2% -Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт - 88,1% - УИХ, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт - 84,9% - Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилт - 84,3% - Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт - 89,9 - Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт - 90,5% - Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт - 87,5% - Байгууллагын ил тод байдлын үнэлгээ - 82,3% - Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ /АТГ-аас гаргасан үнэлгээ/ - 80,0% - Засаглалын үзүүлэлтийн үнэлгээ - 91,2% - Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ - 83,7% - Хэрэглэгчийн үнэлгээ - 63,2%-тай байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг ХХААЯ-ны 2016 оны 01/975 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.</p>	
67.			Хэрэглэгчийн үнэлгээ хийх	2016 оны хэрэглэгчийн үнэлгээ хийх тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 2 байгууллагад тендерийн урилга хүргүүлж, тендерийн баримт бичгийг хүлээн аваад байна.	70
68.			Аймгуудын ХХААГ-ын 2015 оны үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ хийх	<p>Үнэлгээний дүнг яамны удирдлагад танилцуулах</p> <p>Хүнс, хөдөө аж ахуйн яамны харьяа 21 аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2015 оны үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий дундаж үнэлгээ 86,7 хувьтай гарч, 2014 оны түвшингээс 5 пунктээр ахисан байна. -Тайлант 2015 онд аймгуудын ХХААГ-ын мал аж ахуйн салбарт хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, үр нөлөөлөлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэн үзэхэд шалгуур үзүүлэлтээр Хэнтий аймаг 95,0, Сэлэнгэ аймаг 90,0, Өмнөговь 89,2, Сүхбаатар аймаг 88,8, Архангай аймаг 88,1 хувиар буюу</p>	100

					<p>хангалттай сайн гэж үнэлэгдэв.</p> <p>- Газар тариалангийн салбарыг үнэлэхдээ “Газар тариалангийн үйлдвэрлэл”, “Газар тариалангийн салбарын бүтээмж”, “Усалгаатай тариалан”, “Хамгаалагдсан хөрс”, “Зоорины хангамж”, “Сургалт”, “Тариалангийн газрын ашиглалт, зохион байгуулалтын чиглэлээр хийсэн ажлын үнэлгээ”, “Тайлангийн чанар” гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг 26 шалгуур үзүүлэлтийг ашиглан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ. Аймгуудын ХХААГ-ын 2015 оны газар тариалангийн салбарын ерөнхий дундаж 85,4 хувьтай үнэлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 5,9 пунктээр нэмэгдсэн байна. 2016 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Удирдах ажилтны зөвлөгөөний үеэр дүнг танилцуулсан.</p> <p>-Үнэлгээ хийгдсэн үзүүлэлтүүдээр мал эмнэлгийн салбарын дундаж үнэлгээ 92,2 хувьтайгаар дүгнэгдэв. Хүнс, хөдөө аж ахуйн газруудын Мал эмнэлгийн хэлтсүүдийн үйл ажиллагааг 7 дэд үзүүлэлтээр үнэлж дүгнэхэд Хөвсгөл, Архангай, Хэнтий аймгууд 95,7 - 96,2 хувийн биелэлттэйгээр эхний 3-н байрт шалгарсан байна.</p> <p>- Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2015 оны санхүүгийн тайланд тухайн аймгийн аудитын газраас хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг 3-н үзүүлэлтээр нэгтгэж дүгнэхэд нийт аймгийн 9,5 хувь нь буюу 2 аймаг 90-ээс дээш, 28.6 хувь нь буюу 6-н аймаг 85-аас дээш, 3.1 хувь нь буюу 8 аймаг 80-аас дээш, 23.8 хувь нь буюу 5 аймаг 75-аас дээш үнэлгээтэйгээр, салбарын хэмжээнд дунджаар 82,6 хувьтай дүгнэгдэв. Санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмж, зөвлөмжийн биелэлт өмнөх онтой харьцуулахад 2,2 пунктээр ахиж, аймгуудаас Орхон-100%, Өмнөговь-95,0%, Дорноговь-87,5% хувиар дүгнэгдэж бусад аймгуудыг тэргүүлэв.</p>	
69.	ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоол		ХХАА-н Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах төсвийн байгууллагын 2015 оны үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ хийх	Үнэлгээний дүнг яамны удирдлагад танилцуулах тоо: хугацаа:	1. Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа нь стратегийн зорилтыг хангахад чиглэсэн нийт болон дотоод 13 ажил үйлчилгээ, газрын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн тусгайлан сонгосон тусгай 3 ажил үйлчилгээ, мэдлэг чадвараа	100

				<p>дээшлүүлэх зорилтын 3 ажил үйлчилгээг 2015 онд нийлүүлэх үр дүнгийн гэрээг байгуулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байна.</p> <p>- Стратегийн зорилтыг хангахад чиглэсэн нийт 13 ажил үйлчилгээ нийлүүлэхээс 7 ажил үйлчилгээ 30 оноогоор, 1 ажил үйлчилгээ 20 оноогоор, 5 ажил үйлчилгээ 10 оноогоор тус тус үнэлэгдсэн.</p> <p>- Стратегийн зорилтыг хангахад чиглэсэн тусгай 4 ажил үйлчилгээ нийлүүлэхээс 1 ажил үйлчилгээ 40 оноогоор, 1 ажил үйлчилгээ 25 оноогоор, 1 ажил үйлчилгээ 20 оноогоор тус тус үнэлэгдсэн.</p> <p>- Мэдлэг чадвараа дээшлүүлэх ажил үйлчилгээний хүрээнд 3 ажил үйлчилгээ хийгдэхээс 2 үйлчилгээ 30 оноогоор, 1 ажил үйлчилгээ 0 оноогоор тус тус үнэлэгдэв.</p> <p>2. Мал хамгаалах сан нь төсвийн ерөнхийлөн захирагчтай 2015 онд байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг 69.8 хувийн биелэлттэйгээр дүгнэв. - Стратегийн зорилтыг хангахад чиглэсэн нийт болон дотоод 9 ажил үйлчилгээ, газрын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн тусгайлан сонгосон тусгай 11 ажил үйлчилгээ, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 2 ажил үйлчилгээг нийлүүлэх үр дүнгийн гэрээг байгуулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байна.</p> <p>3. Малын удмын сангийн үндэсний төв нь төсвийн ерөнхийлөн захирагчтай газрын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн нийт болон дотоод 26 ажил үйлчилгээ, газрын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн тусгайлан сонгосон тусгай 2 ажил үйлчилгээ, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 9 ажил үйлчилгээг нийлүүлэх үр дүнгийн гэрээг байгуулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байна.</p> <p>Үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд тусгагдсан нийт ажил үйлчилгээний биелэлтийг 27,3, тусгай захиалгат ажил үйлчилгээг 32,5, мэдлэг чадвараа дээшлүүлэх, дотоод болон бусад ажил, үйлчилгээ 29,4 оноогоор, нийт дундаж 89,2 оноогор дүгнэгдэв.</p> <p>4. Мал эмнэлэг үржлийн газар, Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори, Мал эмнэлгийн</p>
--	--	--	--	--

					эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори зэрэг харьяа байгууллагын сайдтай байгуулсан гэрээний 2015 оны жилийн эцсийн үр дүнгийн биелэлтийг дүгнэж, үнэлгээг тайлагнасан. 5. Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2015 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнгийн ерөнхий үнэлгээг аргачлалын дагуу 5 үзүүлэлтээр дүгнэхээс 3 үзүүлэлтээр дүгнэсэн ба дундаж үнэлгээ 74,7 хувьтай байна. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг сангийн захирлын 2015 оны үр дүнгийн гэрээний хавсралт гэж үзэн үнэлгээг нэгтгэсэн.	
70.		Аймгуудын ХХААГ болон сумдын Мал эмнэлэг, үржлийн албаны үйл ажиллагааны үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Дорнод аймгийн ХХААГ-ын үйл ажилла-гаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.	ТНБД-аас баталсан Дорнод аймгийн ХХААГ-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжийн дагуу 2016 оны 05 дугаар сарын 16-26-ны өдрүүдэд тус аймгийн 9 сум, ХХААГ-т томилолтоор ажиллав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг Дорнод аймгийн ХХААГ-т хүргүүлэв.	100	
71.		Гадаадын төслийн хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд дотоод аудит хийх	- Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл - Малын эрүүл мэнд төсөл - Ногоон алт төслийг Сангийн яамтай хамтран гүйцэтгэх	- Хөвсгөл, Завхан аймгуудад томилолтоор ажиллах удирдамж батлагдсан боловч НҮБ-ын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хөдөө аж маркетинг” төслийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүй хүлээгдэж байна. Тус аймгуудын ХХААГ-т ажиллах баримт бичгийг бүрдүүлэн судалгааг бүрэн гүйцэтгэсэн болно. -Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Ногоон алт” төслийн үйл ажиллагаанд гүйцэтгэсэн дотоод аудитын тайланг хянав. Уг төсөл хэрэгжиж буй Баянхонгор аймгийн Баянлиг, Богд, Баян-Овоо, Гурванбулаг, Архангай аймгийн Тариат, Өндөр-Улаан, Чулуут, Их тамир сумдын бэлчээр ашиглалтын холбоо, Аймгийн бэлчээр ашиглалтын холбоодыг хамруулан Сангийн яамтай хамтран гүйцэтгэв. Төслийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг хийж гүйцэтгэхдээ тулгарч буй асуудлуудыг дүгнэж, илэрсэн зөрчил дутагдлыг засч сайжруулах чиглэлээр дүгнэлт, зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100	

72.	"Төсвийн тухай" хуулийн 69 дүгээр зүйл, Засгийн газрын 2014 оны 402 дугаар тогтоолоор баталсан ХХААЯ-ны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр	2.6.6.2. салбарын бодлого, төсвийн хэрэгжилтэд дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж өгөх;	ХХАА-н сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй төсвийн байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт, шалгалт, дотоод аудит хийх,	Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Дундговь, Хөвсгөл аймгуудийн ХХААГ-уудад үйл ажиллагааны болон санхүүгийн дотоод аудит хийсэн байна.	<p>- Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторийн 2015 оны 4 дүгээр улиралд үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд гүйцэтгэсэн дотоод аудитын тайланг Дотоод аудитын хорооны гишүүдэд танилцуулан шийдвэрийг хүргүүлэн зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хүлээн авч хяналтад өгөв.</p> <p>- Аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2015 оны санхүүгийн тайланд тухайн аймгийн аудитын газраас хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг 3 үзүүлэлтээр нэгтгэж дүгнэхэд нийт аймгийн 9,5 хувь нь буюу 2 аймаг 90-ээс дээш, 28,6 хувь нь буюу 6-н аймаг 85-аас дээш, 3,1 хувь нь буюу 8 аймаг 80-аас дээш, 23,8 хувь нь буюу 5 аймаг 75-аас дээш үнэлгээтэйгээр, салбарын хэмжээнд дунджаар 82,6 хувьтай дүгнэгдэв.</p> <p>- Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө, Хөгжлийн банкны эргэн төлөгдөх нөхцөлөөр санхүүжигдсэн Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Дархан салбарын үр тариа хадгалах агуулахын худалдан авах үйл ажиллагаанд дотоод аудит хийж 4 заалт бүхий аудитын хорооны тогтоол гаргуулж, тогтоолын биелэлтийг хяналтад авч ажиллаж байна.</p> <p>Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2012-2015 он, 2016 оны эхний 6 сарын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хийж, ургамал хамгаалал, тэг эдлэншүүлэлтийн арга хэмжээ, бага оврын БОТ трактор, үйлдвэрийн баазын тоног төхөөрөмжийн ашиглалт хадгалалт хамгаалал, шилэн дансны хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгийн тооллого тооцоо бодолтын арга хэмжээг шалгаж явцын тайланд тусгаж ажилласан. Аудитын ажил үргэлжилж байна.</p> <p>- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын "Дотоод аудит хийх тухай" 2016 оны А-14 дугаар тушаалаар баталсан ажлын хэсгийн удирдамжийн дагуу дараах ажлуудыг хийлээ. Үүнд:</p> <p>1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл</p>	100
-----	--	--	--	--	---	-----

				<p>ажиллагаанд аудит хийж, Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>2. Мал хамгаалах сангийн үйл ажиллагаанд аудит хийж, Дотоод аудитын хороогоор 2016 оны 11 дүгээр сарын 21-нд хэлэлцүүлэн зөвлөмж гаргуулан холбогдох газруудад хүргүүлэв.</p> <p>- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас олгосон зээлийн хүрээнд хэрэгжсэн болон хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдэд хяналт, шалгалт хийх 4 дэд ажлын хэсгийг байгуулсан. Дэд ажлын хэсгүүдийн хийж буй шалгалтын явцын тайлан мэдээллийг авч нэгтгэн тухай бүр газрын удирдлагад танилцуулсан. Үүнд:</p> <p>- Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй Дарханы 36,0 мян.тоннын багтаамжтай элеваторт хийсэн шалгалтын хэсэг тайлан, дүгнэлтээ Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлэн, гарсан тогтоолыг ХЗЯ, МУХБ-нд тус тус 1 хувийг хүргүүлэхээр бэлтгэж байна.</p> <p>- Газар тариалангийн дэд ажлын хэсэг-Чингис бондын санхүүжилтээс зээл авсан хүлэмжийн 10 ААН,</p> <p>- Хөнгөний салбарын дэд ажлын хэсэг - Арьс ширний 16 ААН,</p> <p>- ЖДҮХС-ийн дэд ажлын хэсэг-94 ААН,</p> <p>- Хүнсний салбарын дэд ажлын хэсэг- тус яамтай байгуулсан бодлогын гэрээний дагуу Улаанбаатар, Дархан хотын хүн амын 2017 оны хаврын улирлын хэрэгцээнд тогтоосон үнээр мах нийлүүлэх компанууд болон бодлогын гэрээ байгуулаагүй боловч зээл нь олгогдсон "Боса импэкс" ХХК-ийн агуулах дахь нөөцөлсөн махны бүрдүүлэлт, тоо хэмжээ, агуулахын үйл ажиллагаа, холбогдох бичиг баримтад хяналт шалгалтыг Хөгжлийн банк, арилжааны банк, Монголын махны холбооны төлөөлөлийн хамт хийж гүйцэтгэсэн байна. Дэд ажлын хэсгүүдэд Хөгжлийн банк болон арилжааны банкуудын төлөөлөл хамтарч шалгалт хийж байна.</p>
--	--	--	--	---

					Ноос, ноолуур, оёдлын салбараас зээл авсан ААН-дээр шалгалт үргэлжилж байна. Сүүний ажлын хэсэг шалгалтаа эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангасан байна.	
<i>Хоёр. Байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон тусгай ажил үйлчилгээ</i>						
Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд						
1.	Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.31.1 заалт	Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарыг бие даасан, цөөн орноос хамааралтай байдлыг арилгахад анхаарч өрсөлдөх чадварыг нь бэхжүүлэх	“Хүнс, хөдөө аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого”- ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах арга хэмжээг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах;	Холбогдох харьяа байгууллага, бүтцийн нэгжээс санал авч тусган Хүнс, хөдөө аж ахуйн Сайдын тушаалаар батлуулсан байна.	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд хүнс, хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр тусгах арга хэмжээг холбогдох харьяа байгууллага, бүтцийн нэгжээс санал авч тусган боловсруулсан. Түүнчлэн тус төлөвлөгөөний төслийг 21 аймагт хэлэлцүүлж, орон нутгийн иргэдийн саналыг тусган боловсруулж Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А/ 60 дугаар тушаалаар батлуулсан.	100
2.	УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол мал үндэсний хөтөлбөрийн 3.1.1 заалт, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.3.78.4 заалт	Мал аж ахуйн салбар дахь хууль тогтоомжийг боловсронгуй болгох, “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;	Мал аж ахуйн хөгжлийг дэмжих тухай хуулийн үзэл баримтлал, хуулийн төслийг ажлын хэсэгтэй хамтран эцэслэн боловсруулах;	Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүү-лэн төслийг боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.	Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, хуулийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан. Малын генетик нөөцийн хуулийн хэлэлцүүлэг, удирдлагаас өгсөн чиглэл, сонгуулийн үйл ажиллагаатай холбоотойгоор хуулийн төслийг боловсруулах хугацаа хойшлогдсон тул ажлын хэсэг байгуулаагүй, хуулийн үзэл баримтлалын төслийг эцэслэн батлуулаагүй.	90
3.	ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.3.78.4 заалт	хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;	Малын генетик нөөцийн тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэхэд нь мэдээлэл, судалгаагаар удирдлагыг хангах;	Холбогдох нэмэлт мэдээ-лэл, судалгаа-гаар удирдла-гыг тухай бүр хангасан байна.	Малын генетик нөөцийн тухай хуулийн төслийг Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтов.	100
4.	Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 93.1 дахь хэсэг	Импортлоор оруулдаг хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болж, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотооддоо хангадаг болох	Тариалангийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулах;	Хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулан батлуулна.	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А-51 дугаар тушаалаар “Тариалангийн даатгалын тухай” хуулийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн 2 удаагийн хурлаар хэлэлцүүлсэн байна. Засгийн газрын бүтэц шинэчлэгдсэнтэй холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2016 оны А-137 дугаар тушаалаар “Тариалангийн даатгалын тухай” хуулийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг шинэчлэн батлагдсан.	30

5.	УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын мянганы хөгжлийн зохилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, УИХ-ын 2014 оны 16 дугаар тогтоол	Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах, эрчимжүүлэн хөгжүүлэх	“Газар тариалангийн тогтвортой хөгжил” хөтөлбөрийг боловсруулан батлуулах;	Хөтөлбөрийн төслийг боловсруулан Засгийн газрын гишүүдийн саналыг тусган Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэх	“Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах богино хугацааны хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж 42 дугаар тогтоолоор батлуулав.	100
6.	Хүнсний тухай хуулийн 9.3	Хүнсний шим тэжээлийн зохистой байдлыг хангах	Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хуулийн төсөл боловсруулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд холбогдох аргачлалын дагуу тооцоолол, тандалт хийх, үзэл баримтлалын төсөл боловсруулах;	Төсөл боловсруулсан байна.	Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хуулийн төсөл боловсруулах асуудлыг “Хууль тогтоомжийг 2016-2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д тусгаж, 2019 онд УИХ-д өргөн барихаар төлөвлөсөн. Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ХХАА-н сайдын 2016 оны А-01 тоот тушаалаар батласан.	30
7.	Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.3, Чөлөөт бүсийн тухай хуулийн 8.4, 24.1. УИХ-ын 2015 оны 75 дугаар тогтоолын 3 дахь заалт	Халх гол” чөлөөт бүсэд дагаж мөрдөх технологийн болон амьтан, ургамлын хорио цээрийн журмыг бат-лан, хэрэгжил-тийг зохион байгуулах; 2/“Халх гол” чөлөөт бүсэд хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийн заг-вар, шинжлэх ухаанд суурил-сан байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх 3/“Халх гол” чөлөөт бүсэд шаардлагатай дэд бүтцийг байгуула	“Халх гол” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /мастер төлөвлөгөө/, чөлөөт бүсэд дагаж мөрдөх технологийн болон амьтан, ургамлын хорио цээрийн журам батлах, чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлэх	Тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байх.	2016 оны УИХ-ын 46 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн Халх гол Үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах шийдвэр гарсан. Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүсийн үйл ажиллагааны талаар Засгийн газрын хуралдаанд болон УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд танилцуулах мэдээлэл бэлтгэн ажиллаж байна. 2016 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн Засгийн газрын 33-р хуралдаанаар Халх гол бүтээн байгуулалтын бүс байгуулах, түүний хэмжээ, хийлийн заагийг тогтоох, тус бүсийн хөгжлийн бодлого төлөвлөлт, зохицуулалт, газар ашиглахтай холбоотой үүсэх харилцааг зохицуулах журам зэргийг хэлэлцэн батлахаар тогтсон байна.	100

8.	“Монгол мал” хөтөлбөрийн 3.4.1.2	Бэлчээрийн менежментийг сайжруулах	Бэлчээрийг ашиглах хамгаалах тухай хуулийн төсөл боловсруулах	Бэлчээр ашиг-лах хамгаалах тухай хуулийн үзэл баримтлал, төслийг боловсруулсан байна.	Бэлчээрийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулан хуулийн үзэл баримтлалыг Хууль зүйн болон Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулан, Засгийн газрын 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн тэмдэглэл гарсан.	100
9.	Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг боловсруулах, төсвийг хуваарилах;	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулж, батлуулах.	ХХАА-н салбарын арга хэмжээг боловсруулж батлуулсан байна.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлд Хүнс, хөдөө аж ахуйн салбарын саналыг тусган Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 68 дугаар тогтоолоор батлуулсан.	100
10.			Хүнс, хөдөө аж ахуйн салбарын 2017 он, 2018-2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төлөвлөгөөний төслийг боловсруулах, батлуулах	Батлагдсан төсвийн сар бүрийн санхүүжилтийн хуваарийг боловсруулж СЯ-нд хүргүүлэн санхүүжилтийг авсан байна.	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын 2017 оны төсвийн хязгаарын саналыг боловсруулан 2016 оны 01/1824 тоот албан бичгээр Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төв байгууллагад хүргүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын 2017 оны төсвийн төслийг боловсруулахтай холбогдуулан харьяа байгууллага, газруудад 2016 оны 02/2035 албан тоотгоор хүргүүлж ажилласан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийг 185,9 тэрбум төгрөгөөр Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар батлуулсан.	100
11.	“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 10 дугаар зүйл, “Төсвийн тухай” хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3 “Шилэн дансны тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3	ХХАА-н салбарын нягтлан бодох бүртгэлийн чадавхийг дээшлүүлэх болон стратегийн төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах мэдээллээр хангах Хүнс, хөдөө аж ахуйн салбарын баг-цын гүйцэтгэлд шинжилгээ хийх	ХХАА-н салбарын 2015 оны жилийн эцсийн болон 2016 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн нэгдсэн тайлан гаргах.	Сангийн яам болон Үндэсний аудитын газарт хүргүүлэн Аудитын зөвлөмж гаргуулсан байх	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын 2016 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргаж Сангийн яаманд хуулийн хугацаанд хүргүүлсэн. Салбарын санхүүгийн нэгтгэсэн тайлан Сангийн яаманд хүргүүлснээр Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн хагас жилийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгуулсан. Хүнс, хөдөө аж ахуйн яамны санхүүгийн хаалтын тайланг гаргаж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эхлэлтийн тайлан гаргаж СЯ-нд хүргүүлсэн.	100
12.	УИХ-ын 2010 оны 23 дугаар тогтоолоор	Салбарын хууль, тогтоомжийн давхардал, хийдэл,	Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг хэрэгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах, хуулийн төслийн талаар	Мастер төлөвлөгөөг батлуулсан,	БОХХАА-н Байнгын хорооны 2016 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдаан, Улсын Их Хурлын чуулганы 2016 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн	70

	баталсан Монгол мал үндэсний хөтөлбөрийн 3.1.1 заалт, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.3.78.4 заалт	зөрчлийг тогтоон боловсронгуй болгох	нийтэд зориулсан мэдээлэл бэлтгэх, сурталчилгаа хийх.	телевиз, сонин, радиогоор нэвтрүүлэг явуулсан байх	нэгдсэн хуралдаанаар тус хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлсэн. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Эрүүл мал - эрдэнэ, Махны экспортыг нэмэгдүүлэх боломж сэдвээр МҮОНРТ, Малчин ТВ, Боловсрол ТВ-тэй хамтран бэлтгэсэн нэвтрүүлэгт оролцож эрхзүйн шинэчлэлийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэсэн. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төслийг Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, гишүүдийн саналыг тусган 12 дугаар сарын 26-ны өдөр дахин хэлэлцүүлэхээр тогтов.	
Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд						
13.	УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоол	Яамны үйл ажиллагааны стратеги бүтцийн өөрчлөл-тийн хөтөлбө-рийн 2.6.2.1	Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг тайлагнах	Тайланг хугацаанд нь чанартай гаргаж хүргүүлнэ.	Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлагдсаны дагуу “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг батлах тухай” тогтоолыг хүчингүйд тооцсон. Тайланг нэгтгэн гаргаж байна.	100
14.	УИХ-ын 2012 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоол	Яамны үйл ажиллагааны стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 2.6.2.1	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг тайлагнах	Тайланг хугацаанд нь чанартай гаргаж хүргүүлнэ.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг эхний хагас жилийн байдлаар нэгтгэн гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэсэн. Мөн тайланг 3 дугаар улирлын байдлаар хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбараар нэгтгэн 2016 оны 09-р сарын 20-нд 01/465 албан тоотоор Сангийн яаманд хүргүүлэв. Жилийн эцсийн байдлаар тайланг нэгтгэн гаргаж байна.	100
15.	УИХ-ын 2012 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоол	Яамны үйл ажиллагааны стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 2.6.2.1	Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн 2016 оны тайланг нэгтгэх	Тайланг хугацаанд нь чанартай гаргаж хүргүүлнэ.	2016 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийг тайланг нэгтгэн гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэсэн. Засгийн газар шинээр байгуулагдсантай холбогдуулан 2016-2020 оны үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө ЗГХЭГ-аас батлагдаж ирээгүй байна.	100
16.	ЗГХЭГ-ын 2012 оны ХЭГ/2342 тоот албан бичиг	Яамны үйл ажиллагааны стратеги бүтцийн	Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар, улирлаар тайлагнах	Тайланг хугацаанд нь чанартай гаргаж хүргүүлнэ.	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг 2016 оны эхний хагас жилийн	100

		өөрчлөлтийн хөтөлбөрийн 2.6.2.1 дэх заалт			болон 3 дугаар улирлын байдлаар нэгтгэн гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэсэн. 2016 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тайлагнахтай холбогдуулан ЗГХЭГ-аас цахим програмд оруулж буй хүнс, хөдөө аж ахуйн салбарын заалтуудыг Аж үйлдвэрийн яам /хуучнаар/-наас шилжин ирсэн хөнгөн, жижиг дунд үйлдвэр хоршооны салбаруудын заалтуудыг шинээр нэмж, биелэлтийг нэгтгэн гаргаж байна.	
17.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль	Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 284.1,2, 5 дах заалт	Төрийн албан хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд үнэн зөв гаргуулж, тайлан мэдээг АТГ-т хүргүүлэх	Хуулийн хугацаанд мэдээ тайланг АТГ-т хүргүүлнэ.	Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргавал зохих яамны болон харъяа байгууллагын 86 албан хаагчдын 2015 оны ХАСХОМ мэдүүлгийг хуулийн хугацаанд нь хүлээн авч, тайланг АТГ-ын даргын 2012 оны 91 дүгээр тушаалын 1, 2, 3, 4 дүгээр хавсралтын дагуу тус тус нэгтгэн гаргаж, мэдүүлэг гаргасан албан хаагчдын нэрсийн жагсаалтын хамт 2016 оны 01/495 тоот албан бичгээр хуулийн хугацаанд нь АТГ-т хүргүүлсэн.	100
18.	Хууль		Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хуульд заасан үүргийг биелүүлэх, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах	Хууль тогтоомжид заасны дагуу үүргийг биелүүлж, төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас 2016 онд Авилгын эсрэг 75 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг боловсруулж, 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдөр ТНБД-аар батлуулан, 01/379 тоот албан бичгээр АТГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд : Яамны цахим хуудаст “Авлигын эсрэг, ХАСХОМ” булан, мөн байгууллагын дотоод сүлжээнд “Авлигын эсрэг үйл ажиллагаа” буланг тус тус нээн ажиллуулж, ХАСХОМ мэдүүлэх заавар, зөвлөмж, маягтууд, сургалтын материал, авлигын хууль, тогтоомжийн тухай түгээмэл асуулт, хариулт зэрэг мэдээллийг байршуулсан. 2016 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр ХАСХОМ гаргагч нарт зориулсан сургалтыг АТГ-тай хамтран зохион байгуулан 47 албан хаагчдыг хамруулж мөн энэ өдөр АТГ-аас хэвлүүлэн гаргасан “Нийтийн албан тушаалтнуудад зориулсан гарын авлага”-ыг түгээлээ. Яамны албан хаагчдыг гэмт хэрэг, авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох хууль, тогтоомжийг таниулан сурталчлах сургалтыг 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдөр АТГ-тай хамтран	100

					зохион байгууллаа. Авлигын эсрэг үйл ажиллагааны 2016 оны төлөвлөгөөний биелэлтийг 2016 оны 01/1102 тоот албан бичгээр хугацаанд нь АТГ-т хүргүүлэв.	
19.	УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоол		Байгууллагын нууцын албан хэргийг хөтлөн явуулах	Нууцын баримт бичиг, хуулийн дагуу хөтлөгдсөн байна.	Яамны бүтэц, зохион байгуулалт шинэчлэн батлагдсантай холбогдуулан Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг шинэчлэн боловсруулан ТЕГ-ын саналыг тус байгууллагын 2016 оны 01/1905 тоот албан бичгээр авч, “Жагсаалт шинэчлэн батлах тухай” ТНБД-ын 2016 оны 10 сарын 17-ны өдрийн А-62 дугаар тушаалаар батлуулж, Төрийн нууцтай танилцах эрх бүхий 32 албан хаагчдаас нууцын баталгааг гаргуулж авч, хадгалж байна. 2016 оны 12 сарын 07-ны өдрийн байдлаар тус яаманд ирүүлсэн төрийн нууцын зэрэглэлтэй 31 албан бичиг хүлээн авч, 27 албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулаад байна.	100
20.	УИХ-ын 2012 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоол		Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журмыг хэрэгжүүлэх	Журамд заасны дагуу мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлнэ.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2016 оны хуралдаанд Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас хэлэлцүүлэх асуудлыг жагсаалтыг 2016 оны 01/117 тоотгоор хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 266 дугаар зарлигаар батлагдсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам"-ын дагуу танилцуулах тойм мэдээний тайланг 2015 оны жилийн эцсийн байдлаар 2016 оны 01/390 тоотгоор хүргүүлсэн.	100
21.	Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол	УИХ-ын 2012 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоол	Иргэдээс Хүнс, хөдөө аж ахуйн сайд болон яаманд ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх	Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгч, тайланг хугацаанд нь хүргүүлнэ.	2016 оны эхний 3 улирлын байдлаар тус яаманд нийт 318 өргөдөл гомдол санал хүсэлт ирснээс бичгээр 87, 11-11 төвд 164, цахимаар 66, биечлэн 1 санал хүсэлт ирсэн байна. Яамны ажилтнуудаас 103 өргөдөл ирснийг шийдвэрлэсэн бөгөөд энэ тоо нийт өргөдөл гомдлын мэдээнд ороогүй болно. Хэрэгжилт эхний 3 улирлын байдлаар 95,9 хувьтай байна. Дээрхи өргөдөл гомдол санал хүсэлтийг агуулгаар нь ангилбал нийт санал хүсэлтийн 49 хувийг ноосны урамшуулал хурдан өгөх тухай, 41 хувийг малчдын амьдрал хүнд байгаа түүхий эд, махны үнийг өсгөх	90

					тухай, тариаланчдын зээлийн асуудал, 18 хувийг дэмжлэг хүссэн, бичил төслийн мөнгө хүссэн өргөдөл эзэлж байна. Жилийн эцсийн мэдээг нэгтгэж байна.	
22.	Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоол	ТЕЗ-ийн Яамны төсвийн шууд захирагчтай байгуулах үр дүнгийн гэрээ боловсруулж, биелэлтийг гаргах	Төсвийн Ерөнхийлөн захирагчийн Яамны төсвийн шууд захирагчтай байгуулах 2016 оны үр дүнгийн гэрээний төсөл бэлтгэх, батлуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж биелэлтийг тайлагнаж холбогдох байгууллагад хүргүүлэх	Төсвийн Ерөнхийлөн захирагч яамны төсвийн шууд захирагчтай байгуулах үр дүнгийн гэрээг Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын да-гуу байгуулж, дүгнэсэн байна.	Төсвийн Ерөнхийлөн захирагчийн Яамны төсвийн шууд захирагчтай байгуулах 2016 оны үр дүнгийн гэрээг хугацаанд нь батлуулан, хэрэгжүүлж ажиллаа. Үр дүнгийн гэрээний жилийн эцсийн биелэлтийг нэгтгэн гаргаж, тайланг холбогдох байгууллагад хүргүүлэхээр ажиллаж байна.	100
23.	Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол	Яамны жилийн ажлын төлөв-лөгөө боловс-руулж, хяналт тавьж, биелэл-тийг холбогдох байгууллагад хүргүүлэх	Яамны 2016 оны жилийн ажлын төлөвлөгөөний төслийг бэлтгэн батлуулж, биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх	Төлөвлөгөөнд газруудаас санал авч тусган боловсруулж батлуулсан байна.	Яамны 2016 оны жилийн ажлын төлөвлөгөөнд газруудаас санал авч нэгтгэн батлуулсан. Төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийг нэгтгэн гаргаж, тайланг холбогдох байгууллагад хүргүүлэхээр ажиллаж байна.	100
24.	Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол	Яамны сарын ажлын биелэлтийг холбогдох байгууллагад хүргүүлэх	Яамны сарын ажлын товч тайланг нэгтгэн боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэх, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн мэдээллийн санд оруулах	Тайланг хугацаанд нь ЗГХЭГ-т хүргүүлсэн, Засгийн газрын хяналт-шинжил-гээ, үнэлгээний нэгдсэн мэдээллийн санд оруулсан байна.	Яамны сарын ажлын товч тайланг нэгтгэн боловсруулж, ЗГХЭГ-т тухай бүр хүргүүлж, Засгийн газрын хяналт-шинжилгээ үнэлгээний нэгдсэн мэдээллийн санд хугацаанд нь оруулж ажиллав.	100
25.	Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын тө-лөвлөгөө, түүний биелэлтийг ЗГХЭГ-т хүргүүлэх	Тус яамнаас Засгийн газрын хуралдаанаар 2016 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг гаргаж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж ЗГХЭГ-т хүргүүлэх	Төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.	Тус яамнаас Засгийн газрын хуралдаанаар 2016 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг гаргаж ЗГХЭГ-т хүргүүлсэн. Төлөвлөгөөний биелэлтийг эхний хагас жилийн байдлаар нэгтгэн гаргасан. Жилийн эцсийн мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.	100

26.	Засгийн газрын 2008 оны 93 дугаар тогтоол	Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 284.7 дах заалт	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудлыг хариуцах, салбарын ТББ-аар гүйцэтгүүлсэн ажлыг тайлагнах	Тайланг хугацаанд нь чанартай гаргаж хүргүүлнэ.	Салбарын хүрээнд Төрийн бус байгууллагатай хамтран ажилласан тайланг 2016 оны 11дүгээр сарын 01-ний өрийн байдлаар нэгтгэж гаргасан. Үүнд: - 26 Төрийн бус байгууллагатай хамтран ажилласнаас төсвөөс санхүүжүүлсэн 9, тухайн байгууллагын төсвөөр 17 ажил, үйлчилгээг гүйцэтгэсэн байна. Мөн салбарын хэмжээнд хамтран ажилладаг төрийн бус байгууллагуудын талаарх товч мэдээллийг холбогдох газруудаас авч нэгтгэн мэдээллийн сан үүсгэв. 2016 оны 11 дүгээр сарын байдлаар хүнсний салбарын 13, хөнгөн үйлдвэрийн салбарын 32, мал аж ахуйн салбарын 7, газар тариалангийн салбарын 7, жижиг, дунд үйлдвэр, хоршооны салбарын 16, бодлогын чиглэлээр 3 нийт 78 Төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна.	100
27.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн БНФУ-д 2015 онд хийсэн айлчлалын үеэр ДМАЭМБ-тай хамтран Сайд нарын анхдугаар хурлыг Монгол Улсад 2016 онд зохион байгуулахаар тохиролцсон.	Монголын бэлчээрийн мал аж ахуйн өв соёлыг хамгаалах, бэлчээрийн мал аж ахуйн онцлогт тохирсон худалдааны стандарт бий болгох	Бэлчээрийн мал аж ахуйтай улс орнуудын Хөдөө аж ахуйн сайд нарын уулзалтыг зохион байгуулах	Бэлчээрийн мал аж ахуйтай улс орнуудын Хөдөө аж ахуйн сайд нарын уулзалтыг өндөр түвшинд зохион байгуулсан байна.	Бэлчээрийн мал аж ахуйтай улс орнуудын Хөдөө аж ахуйн сайд нарын уулзалтыг зохион байгуулах төлөвлөгөөг гаргаж, төсөв зардлыг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж, олон улсын байгууллага, донор орнууд руу албан ёсоор хүсэлт гарган холбогдох арга хэмжээг авч ажилласан. Хурлын товыг дипломат шугамаар ДМАЭМБ-тай урьдчилсан байдлаар тохирсон. Ерөнхийлөгчийн Тамгын газраас товыг баталгаажуулах, зохион байгуулах асуудлаар чиглэл хүсэж, шийдвэр гаргуулах тухай албан тоотыг хүргүүлсэн хэдий ч одоог хүртэл тодорхой хариу, чиглэл ирүүлээгүй тул Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдах энэхүү өндөр дээд хэмжээний уулзалтыг Ерөнхийлөгчийн тамгын газраас ирүүлсэн шийдвэр, чиглэлгүйгээр ажиллах боломжгүй байна.	30
28.	Үндэсний зөвлөл байгуулах тухай Засгийн газрын 268 дугаар тогтоол	Монголын хөдөө аж ахуйн уламжлалт өв соёлыг хамгаалах,	Монголын хөдөө аж ахуй өв нутгийг НҮБ-ын Даян дэлхийн хөдөө аж ахуйн чухал өв соёлын тогтолцоонд (GIAHS) бүртгүүлэх	Монголын хөдөө аж ахуй өв нутгийг НҮБ-ын Даян дэлхийн хөдөө аж ахуйн чухал өв соёлын тогтолцоонд (GIAHS) бүртгүүлсэн байх	Үндэсний болон Даян дэлхийн хөдөө аж ахуйн өв нутгийг бүртгэх, дэвшүүлэх тухай Үндэсний зөвлөлийн тогтоолын төслийг батлахаар ажиллаж байна. Засгийн газрын шинэ бүтэц зохион байгуулалттай холбогдуулан Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, тогтоолын төслийг дахин танилцуулах асуудлаас шалтгаалан түр хугацаанд тус ажил хойшлоод байна.	30

29.	УИХ-ын 2015 оны 11 сарын 26-ны өдрийн 104 –р тогтоол	Монголын мал сүргийг эрүүлжүүлэх	Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хооронд Монголын мал сүргийг эрүүлжүүлэх хамтарсан хөтөлбөрийн хоёрдугаар үе шатыг хэрэгжүүлж эхлэх	Мал эрүүлжүүлэх хөтөлбөрийн 2 дугаар үе шат хэрэгжиж эхэлсэн байх	Мал эрүүлжүүлэх хөтөлбөрийн 2 дугаар үе шатыг хэрэгжүүлж эхлэх ажлын хүрээнд ОХУ-д 2 удаагийн айлчлал хийж хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаарх албан ёсны уулзалт яриа хэлэлцээг хийж байна. ОХУ-ын буцалтгүй тусламжаар нийлүүлэх боломжтой 7,376.20 сая тун шүлхий өвчний эсрэг вакцины үзүүлэлтийн талаарх албан бичгийг ОХУ-аас МУ-д суугаа Элчин сайдын яамнаас ирүүлсэн. Мөн дээрх хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг хариуцах Монгол, Оросын хамтарсан Ажлын хэсгийг байгуулах асуудлыг Хөдөө аж ахуйн Ажлын хэсгийн гуравдугаар хуралдаанаар хэлэлцүүлж, тохиролцоонд хүрэх чиглэлээр ажиллаж байна.	90
30.	“Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоол	Гадаад орон, олон улсын байгуулагатай ЭЗХА-г хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх	Биокомбинат ТӨҮГ-ыг шинэчлэх төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр ажиллах.	Сонгино дахь Биокомбинат ТӨҮГ-ыг шинэчлэх төсөлд Унгар улсын оруулах хүүгүй 25 сая америк долларын хөнгөлттэй зээлийн хэрэгжилтийг эцэслэх	Унгар Улсын Ерөнхий сайд Виктор Орбаны 01 дүгээр сард Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн тухай Монгол Улс, Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулсан. Унгар Улсад албан айлчлал хийж Биокомбинат ТӨҮГ-ын шинэчлэлийг Унгар Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэхтэй холбогдуулан хоёр талаас Ажлын хэсгийг байгуулсан. Айлчлалын мөрөөр Хамтарсан ажлын хэсгийн Монголын талын бүрэлдэхүүнийг батлан Биокомбинат ТӨҮГ-ын техникийн шинэчлэлийн ажлын даалгаврыг боловсруулан айлын талд хүргүүлсэн. Зээлийн гэрээг байгуулах ажлаар Сангийн яамтай холбогдон шинэчлэлийн ажлыг 2017 оны хавраас эхлүүлэхээр ажиллаж байна.	70
31.	МУ-ын ХХААЯ болон Япон Улсын Шизүока мужтай хамтран ажиллах “Санамж бичиг”	Монголын хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд таниулах, шинэ зах зээл нээх	Япон Улсын Шизүока Мужид зохион байгуулагдах “Фүжи уулын үзэсгэлэн” хүнсний экспод Монголын аж ахуйн нэгжүүдийг оролцуулах арга хэмжээг зохион байгуулах	Япон улсын Шизүока мужид хүнсний экспод монголын аж ахуйн нэгжүүд оролцсон байх	Үзэсгэлэнд Япон улсын нийт 350 гаруй хүнс, газар тариалангийн аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүнээ танилцуулан оролцов. Монголын талаас Тесо ХХК, Жавхлант групп ХХК-ууд өөрсдийн бүтээгдэхүүн болох гурил, гоймонгоо танилцуулав. Энэ үеэр Монголын хөрсөнд ургасан гурвалжин будаагаар хийсэн гоймонгийн амталгааг хийж оролцогчдод сурталчлав.	100
32.	Монгол-Японы стратегийн	Хоёр орны хүнс, хөдөө аж ахуйн	Монгол-Японы Хөдөө аж ахуйн II дугаар Форум	II форум зохион байгуулагдаж хоёр	Монгол Японы Хөдөө аж ахуйн II форумыг Японы Хоккайдо мужийн Обихиро хотод 2016 оны 07 дугаар	100

	түншлэлийн хөтөлбөр	салбарт бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг дэмжих		талын хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчид харилцан мэдээлэл солилцож цаашдын хамтын ажиллагааг эхлүүлсэн байх.	сарын 25-29-ны өдрүүдэд Японы талтай хамтран зохион байгуулав. Хуралд ХХААЯ, ХААИС, МУИС болон Хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын 30, Японы талаас 100 гаруй нийт 130 төлөөлөгч оролцов. Хуралд оролцогсад хоёр орны Хөдөө аж ахуйн бизнесийн боломж, Монгол дахь шууд хөрөнгө оруулалтын орчин, Монгол Улсын газар тариалангийн аж ахуйг шинэчлэх хөгжүүлэх боломж, ХАА-н хоршооллын бүтэц, үйл ажиллагаа, Монгол орны эмийн ургамлын өнөөгийн байдал, цаашдын төлөв гэх асуудлаар мэдээлэл солилцож, хамтран ажиллах чиглэлээр санал солилцсон.	
Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд						
33.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.5.2, 6.7 дахь заалт, 2011 оны Засгийн газрын 304 дүгээр тогтоол	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх	Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтын хэрэгжилт, тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх арга замын талаар сүү үйлдвэрлэгчдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, нэмэлт өөрчлөлтийн санал боловсруулах	Нэмэлт өөрчлөлтийн саналыг боловсруулсан байна.	Дэлхийн банкны групп, Глобал Коммунитиес ОУБ, Монголын Хүнсчдийн холбоо, Монголын үхэр үржүүлэгчдийн нэгдсэн холбоодтой хамтран “Сүү үйлдвэрлэл-тогтвортой хөгжил” онол практикийн бага хурал, хэлэлцүүлгийг 2016 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулж, эрдэм шинжилгээ сургалтын байгууллагууд, эрдэмтэн судлаачид болон сүү үйлдвэрлэлийн сүлжээнд ажиллаж буй бүхий л төлөөллийн 170 орчим хүн оролцсон. Тус чуулга уулзалтын зорилго нь Сүү үйлдвэрлэлийн салбарын тогтвортой хөгжлийг бий болгоход ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан, жигд хүртээмжтэй үнээний түүхий сүүг үйлдвэрлэх боломж, техникийн зохицуулалтын хэрэгжилт, тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх арга замын талаар гарцыг тодорхойлох, ферм, үйлдвэрүүдийн хамтын ажиллагааг өрнүүлэх, тэдгээрийн идэвх санаачлагад тулгуурлан салбарын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд тал бүрийн хамтын ажиллагааг өрнүүлэхэд оршсон.	100
34.	ЗГ-ын 2012 оны 120 дугаар тогтоол, ЗГҮАХХАХТ-ний 167.7 дахь заалт	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байд-лын үзүүлэлт, норм, нормати-выг шинэчлэн боловсруулах	Хүнсний улаанбуудайн стандартыг шинэчлэн боловсруулах, хэлэлцүүлэх	Стандартыг шинэчлэн боловсруулагдсан байх, хэлэлцүүлэг хийгдсэн байх	Улаанбуудайн стандартыг шинэчлэн боловсруулах асуудлаар холбогдох байгууллагуудаас санал авч 2016 оны 05 дугаар сард хэлэлцүүлэг зохион байгуулсан. Стандартын төслийг шинэчлэн боловсруулсан.	100

35.	Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 242 дахь заалт	Органик хөдөө аж ахуйг хөгжүүлэх эдийн засаг, санхүү банкны тааламжтай орчныг бүрдүүлж, Органик монгол үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	Органик хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж, хэлэлцүүлэх	Үндэсний хөтөлбөр боловсруулж, хэлэлцүүлсэн байна.	<p>“Органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн төсөл /шаардлагатай нөөц/-ийг боловсруулах, хэлэлцүүлэг хийх” арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, үнийн саналыг тус яамны 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 04/1883 тоот албан бичгээр авч байна.</p> <p>Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалтын дагуу Органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн төслийг оновчтой бодлогын хувилбарт үндэслэн шаардлагатай нөөцийг нарийвчлан төлөвлөж боловсруулахаар ажиллаж байна.</p> <p>“Хүнсний тухай” хуульд “органик хүнсний холбогдсон харилцааг хуулиар зохицуулна” гэж заасны дагуу “Органик хүнсний тухай” хуулийн болон “Органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулах ажлын хэсгийг 34 гишүүнтэйгээр ТНБД-ын 2012 оны А/73 тушаалаар байгуулж, хөтөлбөрийн төслийн эхний хувилбарыг боловсруулж хэлэлцүүлсэн.</p> <p>Хөтөлбөрийн төсөлд 4 зорилтын хүрээнд хамрагдах 17 үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлэхээр тусгасан. Органик хүнсний баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлэх, органик газар тариалан, МАА, хүнс үйлдвэрлэгчдэд дэмжлэг үзүүлэх, органик хүнсийг баталгаажуулах, бүртгэх, мэдээллийн сан байгуулах, органик Хүнс, хөдөө аж ахуйн талаар олон улсын жишигт тулгуурлан сургалт, сурталчилгаа, судалгаа явуулах гэсэн зорилттой болно.</p>	100
36.			Органик хүнсний тухай хуулийг дагалдан гарах журмуудын төслийг холбогдох газартай хамтран боловсруулах, хэлэлцүүлэх	Журмуудын төсөл бэлэн болсон байна.	<p>- Органик зөгийн аж ахуй эрхлэхэд баримтлах журмын төслийг боловсруулж, МЭҮГ, Зөгийчдийн холбооноос албан ёсны санал авч, www.mofa.gov.mn цахим хуудасны “төсөл, хэлэлцүүлэг” хэсэгт байршуулж, цахимаар санал авах ажлыг зохион байгуулав.</p> <p>- Органик газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэхэд баримтлах журмын төслийг боловсруулж, Хоршоологчдын Холбооноос санал авч, www.mofa.gov.mn цахим хуудасны “төсөл,</p>	100

					хэлэлцүүлэг” хэсэгт байршуулж, цахимаар санал авах ажлыг зохион байгуулав. - Органик мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэхэд баримтлах журмын төслийг боловсруулж, МЭҮГ-аас санал авч, www.mofa.gov.mn цахим хуудасны “төсөл, хэлэлцүүлэг” хэсэгт байршуулж, цахимаар санал авах ажлыг зохион байгуулав.	
37.	Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 273.3	“Архигүй монгол хүн” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан журмын төслийг шинэчлэн боловсруулах, хэлэлцүүлэх	Журмын төслийг дахин хянаж, боловсруулсан байна.	Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн талаарх журмын төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах тухай Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А-241 дүгээр тушаал гаргуулав. Дээрх хэлэлцүүлэгтэй холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2004 оны 58 дугаар тушаалаар баталсан “Согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд хяналт тавих журам”-ын төслийн эхний хувилбарыг шинэчлэн боловсруулж хэлэлцүүлсэн. Спиртийн үйлдвэрлэлд ашиглаж буй 2016 оны ургацаас авсан буудайн хэмжээг спиртийн үйлдвэрээс авч нэгтгэн, удирдлагад хүргүүлэв. АҮЯ-ны /хуучнаар/ байгуулсан “Импортын согтууруулах ундааны техникийн зохицуулалт”-ын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж, ажлын хэсгээс тус техникийн зохицуулалтыг батлуулсан.	100
38.	Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 68.1, 77.1, 77.2, 77.4, 270.1, 77.5 дахь заалт, УИХ-ын 2015 оны 108 тоот тогтоол ЗГ-ын 320, 321-р тогтоол	Мах, махан бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгах зорилгоор махны нийлүүлэлтийн шинэ тогтолцоог бүрдүүлэх	Мал төхөөрөх, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх	Техникийн зохицуулалтын төслийг боловсруулж, ЗГ-т хүргүүлсэн байна.	Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулах, хэлэлцүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан зөвлөх С.Энхбаяртай Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А-210 дугаар тушаалын дагуу 2016 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. Гэрээний дагуу хийгдсэн ажлыг хүлээн авч, хэлэлцүүлэг зохион байгуулахаар ажиллаж байна.	90

39.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.5.2 , 6.7 дахь заалт	Өндөг, өндгөн бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлт, түүнийг боловсруулах, үйлдвэрлэх нөхцөл, шаардлагыг техникийн зохицуулалтад тусгах	Өндөг, өндгөн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх	Техникийн зохицуулалтын төслийг боловсруулсан байна.	“Өндөг, өндгөн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ын төслийг боловсруулав.	70
40.	Төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 4.1.14	Нийтийн хоол үйлдвэрлэлийн хоолны шим тэжээл, чанар, түүнд тавих хяналтыг сайжруулах, ний-гийн хоолны үйлдвэрлэлд зэрэглэл тогтоох	Нийтийн хоолны үйлдвэрийн газрын зэрэглэл тогтоох журмын төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, холбогдох байгууллагаас санал авах	Журмын төслийг боловсруулсан байна.	“Нийтийн хоолны газруудад зэрэглэл тогтоох журам”-ын төслийг боловсруулсан боловч 2015 оны 06 дугаар сарын 19-ни өдөр УИХ-аар батлагдсан “Захиргааны ерөнхий хууль”-ийн дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрх хэмжээний хүрээнд баглагдахгүй, харин Хүнсний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан батлуулах боломжтой байгаа тул хүлээгдэж байна.	70
Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд						
41.	Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоол.	Мал аж ахуйн арга ажиллагааг боловсронгуй болгох, малын ашиг шимийн гарц, чанарыг нэмэгдүүлэх болон нийгэмд оруулж байгаа малчдын хувь нэмрийг үнэлж урамшуулна.	“Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний малчдын бүлэг”, “Улсын тэргүүний фермер”-ийг шалгаруулах асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх, шагнал гардуулах ажлыг зохион байгуулах	Засгийн газрын тогтоолоор шийдвэрлүүлэн шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулсан байна.	Аймгуудаас ирсэн тэргүүний малчдын материалыг Улсын сайн малчин шалгаруулах журмын дагуу шалгаруулж, Засгийн газрын 2016 оны 89 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлсэн. Үүнд: Улсын сайн малчин-118, улсын тэргүүний фермер-4, бүгд 122 малчныг шалгаруулж, шагналыг орон нутагт нь гардуулах ажлыг зохион байгуулсан. Мөн Засгийн газрын 2016 оны 45 дугаар тогтоолыг үндэслэн Улсын сайн малчны эхнэр/нөхөр/-ийг энэ онд хамт шагнаж урамшуулсан болно.	100
42.	“Монгол мал” үндэсний хөтөлбөр. 3.2.3.	Малын үржлийн ажил, үйлчилгээний чадавхийг сайжруулж, хүртээмж үр дүнг дээшлүүлнэ.	Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг, ангилалт хийж стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх, дутагдаж буй хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавих ажлыг холбогдох агентлаг, орон нутагтай хамтран зохион байгуулах	Баталгаажсан үүлдэр, омгийн үржлийн малын анги, чанар тогтоогдсон байна.	Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийх, санхүүжилтыг шилжүүлэх тухай Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А-26 дугаар тушаал гаргуулав. Тушаалын дагуу Мал эмнэлэг, үржлийн газар нь Архангай, Баянхонгор, Булган, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Ховд, Хэнтий аймгуудын Хүнс, хөдөө аж ахуйн газартай гэрээ байгуулж, хэрэгжилтийг зохион байгуулсан. Үүнд: - Малын үзлэг, ангилалтын ажлыг 2016 онд аймаг, орон нутгийн саналыг харгалзан тухайн бүс нутагт үндсэн сайжруулагчаар ашиглах бүрэн боломжтой, үржил селекцийн ажлыг жил бүр тогтмол хийж	100

					<p>хэвшсэн, цаашид үүлдэр, омгоор баталгаажуулан ашиглах мал үржүүлж буй 10 аймгийн 22 сумдыг хамруулан зохион байгуулав.</p> <p>- Үзлэг, ангилалтанд хамрагдсан 10 аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар мал үржлийн ажил үйлчилгээ явуулдаг 17 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан 203,0 мянган малд үзлэг ангилалт хийж анги, чанарыг тогтоов.</p> <p>- Үзлэг ангилалтанд 8,5 мянган хээлтүүлэгч, 194,5 мянган хээлтэгч мал хамрагдаж, хамрагдсан нийт малын 13,6% буюу 27,6 мянган толгой мал шилмэл ангийн, 32,6% буюу 66,2 мянган толгой мал үржлийн нэгдүгээр ангийн шаардлагыг хангасан дүнтэй байна.</p> <p>- Улсын хэмжээнд 279 өрх, 6 аж ахуйн нэгжид үржлийн мал бойжуулах эрх олгон 26,9 мянган толгой хээлтэгчийг үржлийн бүртгэлд авав.</p> <p>- Ангилалтанд хамрагдсан нийт хээлтүүлэгчийн 63,2 хувь /5420 толгой/, хээлтэгчийн 45,4 % /88,3 мянган толгой/ нь шилмэл, I ангийн шаардлага хангасан байна.</p>	
43.	УИХ-ын 30 дугаар тогтоол, Засгийн Газрын 2013 оны 394 дугаар тогтоолын 1, 2-р хавсралт	Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанараас хамаарсан эдийн засгийн урамшуулал бий болгон хэрэгжүүлнэ	Малчдад ноосны урамшуулал олгох арга хэмжээг Мал хамгаалах сантай хамтран зохион байгуулах	Үндэсний үйлдвэрт тушаасан хонь, тэмээний ноосны урамшуулал хугацаандаа олгогдсон байна.	<p>- Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А-38 дугаар тушаалын дагуу үндэсний үйлдвэрт ноосоо бэлтгэн тушаасан хоршооны гишүүн 21 аймаг, нийслэлийн нийт 74387 малчин, мал бүхий этгээдийн 16,8 мянган тн ноосонд 18,6 тэрбум төгрөг олгох ажлыг зохион байгуулсан.</p> <p>- Мөн УИХ-ын 2016 оны 44, 45 дугаар тогтоолуудыг үндэслэн хоршооны гишүүн бус ноосоо бэлтгэн тушаасан малчдад холбогдох урамшууллыг тооцож 5246 малчин, мал бүхий этгээдийн 673,1 тн ноосонд 735,8 сая төгрөгийн урамшуулал олгох ажлыг зохион байгуулсан.</p>	100
44.	“Монгол мал” үндэсний хөтөлбөр 3.2.1.2	Хангайн бү-сийн аймгуу-дад өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үх-рийн эрчимж-сэн аж ахуй, говь хээрийн бүсэд өндөр ашиг шимт хонь, ямааны	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд таримал тэжээл тариалах болон сайн чанарын тэжээлийн үр бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлсэн байна.	Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн таримал тэжээл тариалах ажлыг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, зээлийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулав. Энэ ажлын үр дүнд эрчимжсэн аж ахуй эрхэлж буй 10 аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлж 2017 онд 100 гаруй га-д малын тэжээл тариалах болон тэжээлийн арвай, хошуу буудай, хөх тариа, царгасны үр нийт 192,0 тн-	100

		аж ахуйг дэмжиж, тариалангийн бүс нутагт дэвшилтэт технологи бүхий фермерийн аж ахуйг хөгжүүлнэ.			ыг бэлтгэж нийлүүлэх боломжийг тус тус бүрдүүлсэн байна.	
45.	“Монгол мал” үндэсний хөтөлбөр 3.2.1.2 Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 72.		Малын эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний анхан шатны нэгжид зээлийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах	Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээний анхан шатны нэгжид зээлийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсан байна	“Малын үржлийн ажил, үйлчилгээ явуулж байгаа хувийн хэвшлийн хуулийн этгээдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх” төслийн сонгон шалгаруулалт явуулж, нийт 15 аймаг, нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн мал үржлийн 30 нэгжид 386,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв. Энэ ажлын үр дүнд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй малын үржлийн анхан шатны нэгжүүдийн чадавхи сайжирна гэж дүгнэж байна. - Мөн ХХААЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А-138 дугаар тушаалын дагуу “Хувийн хэвшлийн мал эмнэлгийн анхан шатны нэгжид дэмжлэг үзүүлэх” төсөл сонгон шалгаруулж, Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А-93 дугаар тушаалаар 23 аж ахуйн нэгжид 180,0 сая төгрөгийн зээлийг олгохоор шийдвэрлүүлж, хэрэгжилтийг зохион байгуулав.	100
46.	Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 75. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 3.2.1.2, 3.5.2.1	Эрчимжсэн мал аж ахуй, гахай, шувуу, зөгийн аж ахуй эрхэлж байгаа аж ахуйг дэм-жих зээлийн санг байгуулж ажиллана. Эрчимжсэн аж ахуй эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийг хөрөн-гө оруулалт, зээл, татварын бодлогоор дэмжинэ.	Эрчимжсэн аж ахуй /сүүний үхэр, гахай, зөгий /эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах	Сүүний чиглэлийн үхрийн болон гахай, зөгийн аж ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлсэн байна. Сүү үйлдвэрлэл болон гахайн тоо, махны хэмжээ нэмэгдсэн байна. Зөгийн бүлийн тоог 200 бүлээр нэмэгдэнэ.	Улаанбаатар, Орхон, Дархан, Төв аймгийн нутаг дэвсгэрт сүүний чиглэлийн үхрийн болон гахай, зөгийн аж ахуй эрхлэж буй хуулийн этгээдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх төсөл сонгон шалгаруулалтыг зарлаж хэрэгжилтийг зохион байгуулав.Үүнд: - Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А-103 дугаар тушаалаар 26 аж ахуй нэгжид нийт 300,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгох шийдвэрийг гаргуулж, хэрэгжилтийг зохион байгуулав. - Гахайн цогцолбор аж ахуйд зээлийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулсан ба төслийн үр дүнд ирэх онд гахайн махны үйлдвэрлэл 200 тн-өөр нэмэгдэх нөхцөл бүрдэнэ. - Импортоор орж ирсэн 205 башкир эх зөгийг иргэн, аж ахуйн нэгжид олгох ажлыг Мал хамгаалах сан, Монголын зөгийчдийн нийгэмлэгтэй хамтран зохион байгуулав.	100

Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд						
47.	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”, “Тариалангийн тухай” хууль	Цаг үеийн ажлын явц, үр дүнг ХХАА-н Сайдын болон Засгийн газрын хуралдаанд танилцуулах	Хаврын тариалалтын бэлтгэлийг хангасан дүн, хаврын тариалалтын дүн, ургацын урьдчилсан баланс, ургац хураалтын дүнгийн тухай танилцуулга бэлтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, холбогдох арга хэмжээг авч ажиллах	Танилцуулга, шийдвэрийн төслийг хугацаанд нь чанартай боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Хаврын тариалалтын бэлтгэл хангасан дүнгийн тухай танилцуулга, шийдвэрийн төслийг боловсруулан 2016 оны 05 дугаар сарын 16-ны Засгийн газрын хуралдаанд танилцуулж импортоор болон дотоодын нөөцөөс олгож байгаа үрийн буудайг тариаланчдад яаралтай олгох, тариалалтыг технологийн хугацаанд шуурхай зохион байгуулахыг тэмдэглэлээр үүрэг болгов. Тариалалтын дүнгийн танилцуулга шийдвэрийн төслийг боловсруулан 2016 оны 06 дугаар сарын 25-ны Засгийн газрын хуралдаанд танилцуулсан. Цаг агаарын төлөв байдалтай уялдуулан хаврын тариалалтын ажлыг энэ оны 05 дугаар сарын 08-наас эхлүүлж, улсын хэмжээгээр 362,4 мянган га-д үр тариа үүнээс 340,7 мянган га-д улаанбуудай, 12,4 мянган га-д төмс, 6,2 мянган га-д хүнсний ногоо, 13,5 мянган га-д малын тэжээл, 50,2 мянган га-д тосны ургамал, нийт 444,9 мянган га-д тариалалт хийсэн.	100
48.	Тариалангийн тухай хуулийн 15.1.1	Тариалангийн салбарт хөнгөлөлтэй зээл олгох ажлыг зохион байгуулах	Хөгжлийн банктай бодлогын гэрээ байгуулах, аж ахуйн нэгж, иргэдийн тариалах талбай, боловсруулах уриншийн хэмжээг гаргаж баталгаажуулах	Тариалангийн салбарт 100.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдож тариалалт, уринш боловсруулалт, ургац хураалтын ажлыг технологийн хугацаанд чанартай зохион байгуулсан байна.	Засгийн газрын 2016 оны 42 дугаар тогтоолоор “Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах” богино хугацааны хөтөлбөр боловсруулж батлуулан, 100,0 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэр бүрдүүлж 2 жилийн хугацаатай газар тариалангийн салбарт олгох шийдвэр гаргуулж, Хөгжлийн банктай хамтран ажиллав. УИХ, Засгийн газрын шийдвэрүүдийг хэрэгжүүлэх, 2016 оны тариалалтыг хэвийн явуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор эхний ээлжинд 2 жилийн хугацаатай, жилийн 12,5 хувийн хүүтэй 25,0 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийг Хөгжлийн банкаар шийдвэрлүүлж, улмаар ХААН, Голомт, Худалдаа хөгжил, Төрийн банкуудтай хамтран ажиллах Санамж бичиг байгуулж, дамжуулан зээлдүүлэх ажлыг эхлүүлснээр өнөөдрийн байдлаар 90 аж ахуйн нэгжид 25.0 тэрбум төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн байна.	90
49.	Монгол Улсын Их Хурлын тогтоол, 2015-11-26, №104. Төрөөс	Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл, УБ хотын	Үйлдвэрлэл, зам харилцаа, агуулахын аж ахуйн дэд бүтцийн нөөцийг ашиглан хадгалалт борлуулалтын логистик сүлжээний менежментийн загварыг	Төмс, хүнсний ногооны хадгалалт борлуулалтын логистик	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Төмс, хүнсний ногооны хадгалалт борлуулалтын сүлжээний тогтолцоо бүрдүүлэх саналыг боловсруулж салбарын хэмжээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд	70

	хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, 3.1.13, 4.1.7	зоорийн аж ахуй, худалдааны төвийг түшиглэн хадгалалт, борлуулалтын сүлжээний менежмент бүтэц бий болгох	боловсруулан турших	сүлжээний менежментийн загвар бүтцийг туршиж хэрэгжүүлсэн байх	оруулсан. Борлуулалтын сүлжээний тогтолцоо бүрдүүлэхэд Швейцарийн хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж байгаа “Монгол ногоо” төсөл, НҮБ-ын ХХАА-н газраас хэрэгжүүлж байгаа “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өртгийн сүлжээ хөгжүүлэх” төсөл зэрэг гадаадын төслүүдтэй хамтран ажиллаж байна. Энэ чиглэлээр гурван удаа хэлэлцүүлэгт оролцож тус бүрд илтгэл тавьж төрөөс хэрэгжүүлэх бодлого, зорилтыг танилцуулсан. Төмс, хүнсний ногооны хадгалалт, борлуулалтын менежмент бүтэц бий болгох зөвлөх үйлчилгээний тендерийн сонгон шалгаруулалт зохион байгуулсан. Тендерт “Монголын логистикийн холбоо” Төрийн бус байгууллага шалгарч ажлыг 10,000,000.0 /арван сая/ төгрөгөөр гүйцэтгэхээр санал ирүүлж гэрээ байгуулсан боловч төслийг хэрэгжүүлээгүй.	
50.	Ургамал хамгааллын тухай хууль	Газар тариа-лангийн үйлд-вэрлэлд туршилт хийгдэн бүртгэлд орсон биологийн гаралтай бодисуудыг ашиглах боломж бүрдүүлэх	“Монгол Улсад хэрэглэх ургамал хамгаалах биологийн гаралтай бодис, бордоог турших, бүртгэх, түүнийг хэрэглэх журам”, бодис, бордооны жагсаалтыг батлуулах	Журмын төслийг боловсруулан батлуулсан байна.	Ургамал хамгааллын тухай хуулийн 8.1.7 дахь заалтын дагуу ургамал хамгааллын арга хэмжээнд ашиглах химийн гаралтай бодисоос бусад бодисыг турших, бүртгэх, ашиглах журмыг Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах гэсний дагуу дээрх журмын төслийг боловсруулан Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А-63 тоот тушаалаар батлуулж, улсын бүртгэлийн 3640 тоот дугаарт бүртгүүллээ.	100
51.	ЗГ-ын 2010 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Чацаргана” хөтөлбөр	Алим, чавганы суулгац үржүүлэх ажлыг эрчимжүүлэх	Алим, чавганы суулгац үржүүлгийн газруудыг байгуулж хурдавчилсан аргаар үржүүлэг хийх, хангамжийг сайжруулах	Алим, чавганы суулгац үржүүлгийн газ-рууд байгуулж дэмжлэг үзүүл-сэн байна. Хурдавчилсан аргаар 2017 оноос жилд 5000 ширхэг цаашид 10000-15000 ширхэг суулгац үйлд-вэрлэж тариа-лалтыг жил бүр 20-30 га-гаар нэмэгдүүлнэ.	Төв, Зүүн, Баруун бүсэд хэрэгжүүлэх “Жимс жимсгэний сорг сорилт, үржүүлгийн ажил” цөм технологийн төслийн саналыг БСШУ-нд хүргүүлээд байна. НҮБ-ын ХХААБ-д хүсэлт гарган, “Жимс жимсгэнэ” төслийг 2017 оноос хэрэгжүүлэхээр шийдвэрлэв. Уг төслөөр алим, чавга зэрэг жимсний суулгацыг турших, нутагшуулах, үржүүлэх ажлыг хийнэ.	50

52.	ЗГ-ын 2010 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Чацаргана” хөтөлбөр	Чацарганы хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, зохистой хэрэглээг тодорхойлох, гадаад дотоод зах зээл, хэрэг-лээг нэмэгдүүлэх, Монгол чацарганы генетик судалгаа, Монгол сорт гаргах	Монгол чацарганы генетик зүй тогтлыг тодорхойлж Монгол чацарганы сорт гаргах ажлыг эрчимжүүлэх, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, зохистой хэрэглээг тодорхойлох	Монгол чацар-ганы генетик зүй тогтлыг тогтоож, Мон-гол сорт гаргах ажлыг эрчим-жүүлж, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тогтоож тухайн чиглэлийн шинжлэх ухааны хэвлэлд нийтлүүлсэн байна.	Бэлчээрийн удирдлага төсөл, МЧТҮҮ Холбоотой хамтран ажиллаж “Чацарганы шүүс” MNS стандартыг олон улсын стандартад нийцүүлэн шинээр боловсруулан, шат шатны хэлэлцүүлэг зохион байгуулж батлуулав. Жимс жимсгэний салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн бага хурлыг зохион байгуулж судлаачдын судалгааны үр дүн, цаашдын чиглэлээр хэлэлцэв. Мөн жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэрийн өнөөгийн байдал, зах зээлийн чиглэлийн судалгааг Монголын жимс жимсгэний холбоогоор гүйцэтгүүлэв.	30
53.	Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоол	Газар тариалангийн салбарт өндөр амжилт үзүүлсэн аж ахуйн нэгж, иргэдийг улсын хэмжээнд шалгаруулах	“Улсын тэргүүний тариаланч”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”-ыг журмын дагуу шалгаруулах, шагнах ажлыг зохион байгуулах	“Улсын тэргүүний тариа-ланч”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”-ыг журмын дагуу шалгаруулж Засгийн газрын тогтоолын төсөл боловс-руулж батлуул-сан, шагналыг бэлтгэж гар-дуулах ажлыг зохион бай-гуулсан байна.	“Улсын тэргүүний тариаланч”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”-ыг холбогдох журмын дагуу шалгаруулж, Засгийн газрын тогтоолоор батлуулсан. Бэлэг дурсгалын зүйл худалдаж авах гэрээг гүйцэтгэгч талуудтай байгуулж хүлээж авах, хүргэх ажлыг цаг хугацаанд нь зохион байгуулсан.	100
54.	Химийн хортой болон аюултай бодисын тухай хуулийн 6.1.3,	Ашиглаж бо-лох пестицид, химийн бор-доо, ахуйн хортон шавж, мэрэгч устга-лын болон ариутгал, халдваргүйтгэлийн бодисын жагсаалт, тэдгээрийн ашиглалтын хэмжээг хүнс, хөдөө аж ахуйн болон эрүүл мэндийн асуу-дал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран жил бүр шинэчлэн батлах	Монгол Улсад 2016 онд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох химийн пестицид, бордооны жагсаалт, хэрэглэх хэмжээг батлуулах	Тогтоосон хугацаанд жагсаалтыг батлуулсан байна. Таримлын өвчин, хог ургамал, хортон шавьжтай тэмцэх арга хэмжээнд хэрэглэснээр ургацын хэмжээ нэмэгдэж, чанар сайжирна.	Монгол Улсад 2016 онд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидын жагсаалт, хэрэглэх хэмжээг УХЭШХ болон Дархан Уул аймгийн УГТХ-ийн Эрдмийн зөвлөлийн хурлын дүгнэлтийг Салбар Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, 2016 оны 02 сарын 29-ний өдрийн БОНХАЖ-ын сайд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд, ЭМС-ын сайдын хамтарсан А-51/А-28/57 тоот тушаалаар батлуулав.	100

Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд						
55.	ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоол	2.6.8.1. салбарын хууль тогтоомж, шийдвэр, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоодын хяналт, шалгалт хийх, дүгнэлт, зөвлөмж өгөх;	Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Үнэлгээний дүнг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн байх	Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах 11 зорилтын 40 арга хэмжээний хэрэгжилтийн ерөнхий дундаж үнэлгээ 88,1 хувьтай дүгнэгдсэн. Зорилтын үнэлгээгээр 6 зорилт 90 хувиар, 1 зорилт 86,2 хувиар, 1 зорилт 83,3 хувиар, 2 зорилт 80,0 хувиар тус тус үнэлэгдэв. Үнэлгээний дүнг Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулан, тайланг 2016 оны 01/305 тоот албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. Тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын цахим сайтуудад байршуулсан.	100
56.			Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Үнэлгээний дүнг ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлсэн байх	Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах 27 зорилтын 86 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ 2015 оны жилийн эцсийн байдлаар 83,2 хувьтай, 2016 оны эхний хагас жилийн байдлаар дунджаар 86,2 хувьтай дүгнэгдсэн нь 2015 оны жилийн эцсийн дүнгээс 3,0 пунктээр өссөн байна. 2016 оны эхний хагас жилийн байдлаар 28 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 56 арга хэмжээ хэрэгжих шатандаа 30-90 хувийн биелэлттэй байна. Үнэлгээний дүнг Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулан, тайланг 2016 оны 01/305 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. Тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын цахим сайтуудад байршуулсан.	100
57.			Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015, 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Үнэлгээний дүнг ЗГХЭГ, СЯ-нд хүргүүлсэн байх	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 2 бодлого, 12 арга хэмжээг хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 82,3 хувиар үнэлэгдэв. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах	100

					<p>арга хэмжээний ерөнхий гүйцэтгэл 2016 оны эхний хагас жилийн байдлаар 37,3 хувьтай үнэлэгдэв. Төлөвлөгдсөн арга хэмжээнээс 2 нь 90,0%, 1 нь 70,0%, 5 нь 50,0%, 10 нь 30,0%, 2 нь 10,0%, 2 арга хэмжээний хэрэгжилт 0%-тай үнэлэгдлээ.</p> <p>Үнэлгээний дүнг Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулан, тайланг 2016 оны 01/305 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд тус тус хүргүүлсэн. Тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын цахим сайтуудад байршуулсан.</p>	
58.			<p>Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн салбарт хамаарах заалтын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</p>	<p>Үнэлгээний дүнг ЗГХЭГ-т хүргүүлсэн байх</p>	<p>ЗГХЭГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний албан ёсны цахим хуудсанд 2015 оны жилийн эцсийн байдлаар Хүнс, хөдөө аж ахуйн яаманд хамаарах нийт 97 тогтоол, шийдвэрийн 158 заалт байгаагаас ХХААЯ-ны үндсэн чиг үүрэгт хамаатай Монгол Улсын хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, Улсын Их Хурал, УИХ-ын Байнгын Хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, тэмдэглэл бүхий нийт 92 тогтоол, шийдвэрийн 152 заалтыг хяналтад авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Дээрх заалтуудын 57 (36.7%) нь бүрэн биелэгдсэн, 101 (65.2%) заалт хэрэгжилтийн шатанд байгаа ба биелэлтийн дүн дунджаар 84,8 хувьтай үнэлэгдэв.</p> <p>- Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэхээр хяналтад авсан заалтуудаас бүрэн хэрэгжсэн болон хугацаа нь дууссан, цаг үеийн асуудлаар гарч зохих үр дүнд хүрсэн 45 шийдвэрийн 77 заалтыг хасуулах саналтай байна. Үнэлгээний дүнг Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулан, албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн, тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын цахим хуудаст байршуулсан.</p>	100
59.	ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоол	2.6.8.1. салбарын хууль тогтоомж, шийдвэр, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл, хамтын ажиллагааны гэрээ,	<p>Салбарт хэрэгжиж буй үндэсний дараах хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, Үүнд:</p> <p>Мал аж ахуйн салбарт: -“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг</p>	<p>Үнэлгээний дүнг ЗГХЭГ-т хүргүүлсэн байх</p>	<p>Салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийн дундаж үнэлгээ 84,96 хувьтай байна. Үүнд: -“Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөр – 78,3% - “Монгол мал” хөтөлбөр – 86,0% - “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөр – 85,6%</p>	100

		хэлэлцээрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоодын хяналт, шалгалт хийх, дүгнэлт, зөвлөмж өгөх;	дэмжих” хөтөлбөр, ЗГ-ын 2010 оны 160 дугаар тогтоол, /2003-2016/ - “Монгол мал” үндэсний хөтөлбөр, УИХ-ын 2004 оны 169 дүгээр тогтоол, /2010-2021/ Хүнс, газар тариалангийн салбарт: -“Чацаргана” хөтөлбөр, ЗГ-ын 2010 оны 60 дугаар тогтоол, /2010-2016/ -“Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөр, ЗГ-ын 2009 оны 32 дугаар тогтоол /2009-2016/		- “Цаа бугын аж ахуйг сэргээх, цаачдын амьдралын түвшинг сайжруулах” хөтөлбөр – 80,1% - “Чацаргана” хөтөлбөр – 94,8%-тай байна. Үнэлгээний дүнг Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулан, албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн, тайланг яамны АСУ –ийн файлын санд, mofa.gov.mn сайтуудад байршуулсан.	
60.	ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоол	2.6.8.1. салба-рын хууль тогтоомж, шийдвэр, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоодын хяналт, шагалт хийх, дүгнэлт, зөвлөмж өгөх;	Гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хүрээнд хэрэгжиж буй дараах төслүүдийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. Үүнд: <u>Мал аж ахуйн салбарт:</u> “Ногоон алт” бэлчээрийн экосистемийн удирдлага төсөл (ШХАгентлаг) “Малын эрүүл мэнд” төсөл (ШХАгентлаг) “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын менежмент” төсөл (ХААХОУС) “Хөдөө аж ахуйн маркетингийн төсөл” (ДДХББХ) /2012-2016/ <u>Газар тариалангийн салбарт:</u> “Монгол улс дахь Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил” төсөл “Буудайн элит үр гаргах, үр үржүүлэх, (Копиа-Монгол төв) “Монгол ногоо” төсөл <u>Хүнсний үйлдвэрийн салбарт:</u> “Монгол улсын органик хөдөө аж ахуйд дэмжлэг үзүүлэх” төсөл (НҮБ, ХХААБ) “Өмнөд-Өмнөдийн хамтын ажиллагааны хүрээнд Хүнсний баталгаат байдал хөтөлбөрийг дэмжих” төслийн II үе шат (НҮБ-ын ХХААБ,) “Загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх цөөрмийн аж	Үнэлгээний дүнг ЗГХЭГ-т хүргүүлсэн байх	Гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хүрээнд хэрэгжиж буй төслийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 84,25 хувьтай байна. Үүнд: - “Загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд цөөрмийн аж ахуйг Монголд хөгжүүлэх” - 73,3% - “Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөрийг дэмжих техник туслалцааны төслийн II үе шат - 82,1% - “Монголын Органик ХАА-г дэмжих” төсөл - 83,6% - “Ногоон алт” бэлчээрийн экосистемийн удирдлага” төсөл - 90,0% - “Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон хөдөөгийн амьжиргаа” төсөл - 90,0% - “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын менежмент” төсөл - 94,3% - “Хөдөө аж ахуйн маркетинг” төсөл - 48,3% - “Малын эрүүл мэнд” төсөл - 84,4% - “Монгол төмс” хөтөлбөр - 93,4% - “Монгол Улс дахь Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил” төсөл - 92,5% - “Буудайн элит үр гаргах, үр үржүүлэх” төсөл - 94,9%-тай байна. Үнэлгээний дүнг Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулан, албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн, тайланг яамны АСУ–ийн файлын санд, mofa.gov.mn сайтуудад байршуулсан.	100

61.	ЗГ-ын 2013 оны 322 дугаар тогтоол	2.6.8.1. салба-рын хууль тогтоомж, шийдвэр, бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоодын хяналт, шалгалт хийх, дүгнэлт, зөвлөмж өгөх;	ахуйг Монголд хөгжүүлэх” төсөл (НҮБ- ын ХХААБ)			100
-----	---	---	---	--	--	-----

.....oOo.....